



НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ  
БАЙГУУЛЛАГА  
МОНГОЛ УЛС



# МОНГОЛ УЛС ДАХЬ НҮБ-ЫН 2023 ОНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2024 оны 3 сар

Зургийг ©ХХААБ

## АГУУЛГА

Өмнөх үг  
Монгол Улс дахь НҮБ-ын удирдлагын баг  
Монгол Улс дахь НҮБ-ын хөгжлийн системийн байгууллагуудтай хамтрагч талууд

### БҮЛЭГ 1: МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд

### БҮЛЭГ 2: НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭГ (ТХХАХ) ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАМААР ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТУУДАД ҮЗҮҮЛСЭН ДЭМЖЛЭГ

- 2.1 НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Хамтын Ажиллагааны Хүрээний үр дүн
- 2.2 НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Хамтын Ажиллагааны Хүрээний чиглэл, үр дүнгийн зорилт, үр дүн
- 2.3 “Тогтвортой хөгжил-2030” хөтөлбөрийн санхүүжилт, түншлэлийг дэмжих
- 2.4 НҮБ-ын хамтын ажиллагааны үр дүн: НҮБ-ын үйл ажиллагааны харилцан уялдаа, үр дүн, нөлөө
- 2.5 Үнэлгээ, НҮБ-ын ТХХАХ -г хэрэгжүүлэх хүрээнд олж авсан сургамж
- 2.6 Санхүүжилт, хөрөнгийн татан төвлөрүүлэлт

### БҮЛЭГ 3: НҮБ-ААС 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

ХАВСРАЛТ:

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:



## ӨМНӨХ ҮГ НҮБ-ЫН СУУРИН ЗОХИЦУУЛАГЧ

2023 он бидний хувьд НҮБ-ын 2023-2027 оны Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (НҮБ-ын ТХХАХ)-г хэрэгжүүлэх их ажлын эхлэл тавигдаж, Монгол Улсын тогтвортой хөгжлийн төлөөх үүрэг амлалтаа үйл хэрэг болгох чухал үйл явдлууд өрнөсөн, чамлахааргүй ололт амжилттай жил байв. НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлж эхэлсэн гарааны жилийн хувьд дорвитой үр нөлөө үзүүлэх санаачилгууд, ахиц дэвшлийн эх суурийг тавьж чадлаа.

Монгол Улс дахь НҮБ нь өнгөрсөн онд

1. Хүний хөгжил, сайн сайхан байдал,
2. Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлт,
3. Хүн төвтэй засаглал, эрх зүйт ёс, хүний эрх

гэсэн стратегийн гурван тэргүүлэх чиглэлийн хүрээнд НҮБ-ын системийн нийт 23 байгууллагатайгаа нягт хамтран ажиллалаа. Бид хамтдаа 158 дэд үр дүнгийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, стратегийн бодлогын чиглэлээр анхан шатны түвшинд хүрч ажиллахын сацуу нийт 51.5 сая ам.долларын санхүүжилтийг татан төвлөрүүлсэн байна.

Үйл явдал хэрхэн өрнөснийг тоо баримт товч, тодорхой өгүүлнэ. Цөөн хэдэн баримт хэлье. НҮБ-ын системийн дэмжлэгтэйгээр Эрүүл насжилтыг дэмжих хөтөлбөрт хамрагдан 250 гаруй мянган ахмад настан амьдралын чанараа сайжруулж, 71 мянган хүн аюулгүй ундны ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ авах боломж нөхцөл бүрдсэн. Түүнчлэн, өртгийн сүлжээг хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргасны үр дүнд Монгол Улсын ингэний сүү, сүүн бүтээгдэхүүний экспорт гурав дахин,

тус салбарт орох хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 10 дахин нэмэгдлээ.

Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй газар нутаг, бэлчээр, усны менежментийн дэвшилтэт арга, туршлагыг нэвтрүүлсний үр дүнд 49 мянган га талбайн доройтсон бэлчээрийг нөхөн сэргээж чадсан бол орон нутгийн иргэд 82 мянган га талбайн бэлчээрийн менежментийг сайжруулж чадсан байна. НҮБ-ээс бодлогын хүрээнд үзүүлсэн дэмжлэгийн үр дүнд сонгуулийн шинэ хуулиар жендерийн 30 хувийн квотыг 2024 оны сонгуульд мөрдөх эрх зүйн орчин бүрдлээ.

Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг (ТХЗ) хэрэгжүүлэх бүхий л хүчин чармайлтыг хурдасгах нь бидний хүлээх үүрэг, зорилго төдийгүй бидний чин хүсэл тэмүүлэл, урам зориг билээ. Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Зорилгын хэрэгжилт, бодлого, үйл ажиллагаанд үнэлгээ хийж, хөгжлийн үр шимээс орхигдох эрсдэлтэй байгаа хүн амын бүлгүүдийг тодорхойлсон Үндэсний сайн дурын хоёр дахь удаагийн илтгэлийг бэлтгэж өнгөрсөн онд НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн улс төрийн өндөр түвшний чуулга уулзалтад танилцуулахад нь Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яаманд дэмжлэг үзүүлсэндээ бид бахархалтай байна.

Тогтвортой хөгжлийн төлөөх Үндэсний чуулга уулзалтыг 2023 оны 9-р сард Монгол Улс зохион байгуулсан нь бид бүхний хамтын хүчин чармайлтыг улам бүр гүнзгийрүүлсэн явдал болсон юм. Чуулганы үеэр Засгийн газар ТХЗ-ыг хэрэгжүүлэх хүчин чармайлтаа түргэсгэх Арван хоёр (12) Хурдасгуур тэргүүлэх чиглэлийг тодорхойлж ТХЗ-ыг хэрэгжүүлэх зорилтуудаа ахиулан шинэчлэх нөхцөл бүрдсэн. Түүнчлэн Монгол Улс

ТХЗ-ын хурдасгуур тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх замын зураглалыг боловсруулж, үндэсний зөвшилцөл, хамтын ажиллагаагаа нягтруулж байгаад бид туйлын талархалтай байна. Монголын нийгэм, тэр дундаа залуучууд, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшил бүгдээрээ ТХЗ-ыг өөриймсгөөр хэрэгжүүлэхээ хүлээн зөвшөөрч тогтвортой, хүртээмжтэй хамтын нийгэмлэгийг бий болгоход тууштай хүчин зүтгэл гаргаж, ололт амжилтаа ахиулахаа дуу нэгтэйгээр илэрхийлж байгаа нь сайшаалтай.

Монгол Улс дахь НҮБ нь боловсролын салбар дахь хувьсал, шинэчлэлийг дэмжиж, цахим хөгжлийн чиглэлээр үзүүлэх дэмжлэгээ үргэлжлүүлсээр байна. Энэ чиглэлээр НҮБ-ын Удирдлагын багийн зүгээс хэрэгжүүлж буй шинэлэг ажил, үр дүнгийн талаар энэхүү тайлангаас танилцах болно. Хүний эрхийн асуудал бол бид бүхний хүчин чармайлт, оролцооны үндэс суурь, тэргүүн шугам, төв цэг юм. Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойн арга хэмжээнд улс орон даяар олон салбар, оролцогч талууд, олон нийт идэвхтэй оролцож байсан нь талархалтай.

Бидний хүчин чармайлт, ололт амжилт улс орны хэмжээнд төдийгүй олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөж байна. НҮБ байгуулагдсан тэмдэглэлт өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Эрхэмсэг ноён Ухнаагийн Хүрэлсүх НҮБ-ын төв байранд зочилсон нь бидний хамтын ажиллагааны 60 жилийн түүхэн дэх анхны айлчлал болсонд гүнээ талархаж байна. Эрхэмсэг ноён Ерөнхийлөгчийн энэхүү айлчлал нь Монгол Улсын тогтвортой хөгжлийг ахиулахад НҮБ чухал үүрэг гүйцэтгэж буйг нотолж байгаагийн тод

илрэл гэж үзэж байна. Түүнчлэн, Монгол Улс дахь НҮБ-ын 2022 оны Үр дүнгийн тайлан нь Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын дунд хамгийн шилдэг бөгөөд бүтээлч тайлангаар шалгарсан нь бидэнд улам зориг өгсөн явдал боллоо.

Илүү тогтвортой хөгжсөн Монгол Улсын төлөөх энэхүү аянд бидэнтэй үргэлж хамт байгаа эрхэм түншүүд, санхүүжүүлэгчид, оролцогч талууддаа Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын баг чин сэтгэлээсээ талархаж байна. Энэхүү тайланд дурдаж буй бахархам үр дүнг чухамдаа та бүхний хувь нэмэр, оролцооны ачаар л бүтээсэн гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Бид 2023 онд ололт, амжилтаа бататгах, шинээр тулгарах сорилт бүрийг даван гарахдаа хэнийг ч орхигдуулалгүйгээр тогтвортой хөгжлийг улам ахиулах гэсэн амлалтдаа тууштай хэвээр байлаа. НҮБ-аас Монгол Улсын хөгжилд оруулж буй хувь нэмрээ гүнзгийрүүлж, ахиц дэвшлийг манлайлж буй НҮБ-ын Удирдлагын баг болон тууштай хичээл зүтгэл гаргаж ажилласан хамт олондоо чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье.

Монгол Улсын илүү тогтвортой, хүртээмжтэй, эрсдэлт тэсвэртэй хөгжлийн төлөөх их аяллаа хамтдаа үргэлжлүүлцгээе.

  
**Тапан Мишра**  
**Суурин Зохицуулагч**

# МОНГОЛ УЛС ДАХЬ НҮБ-ЫН УДИРДЛАГЫН БАГ

Тaпaн Мишрa Суурин зохицуулагч	Винод Ахужа Суурин төлөөлөгч	Сакпохаусэт Мэнг (Сет) Монгол Улсыг хариуцсан Захирал	Чанхи Ли БНХАУ, Монгол Улсыг хариуцсан товчооны захирал	Жьюзеппе Кроцетти БНХАУ, Монгол Улсыг хариуцсан товчооны дарга	Силвий Битом Бүс хариуцсан ахлах мэргэжилтэн	Ацуко Окуда Ази, Номхон далайн бүс нутаг хариуцсан захирал	Рори Мунговен Ази, Номхон далайн бүсийн газрын тэргүүн
СУУРИН ЗОХИЦУУЛАГЧ	ХХААБ	НҮБ-ХААХОУС	ОУХБ	ОУШХБ	НҮБ-ОУХТ	НҮБ-ОУЦХБ	НҮБ-ХЭДК
Имонн Мерфи Ази, Номхон далайн бүс, Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийг хариуцсан багийн захирал	Жиан-Филипп Роде Хөтөлбөрийн мэргэжилтэн	Матильда Димовска Суурин төлөөлөгч	Марко Тосано Ривалта Бүс хариуцсан ахлах мэргэжилтэн	Южон Ким Ахлах мэргэжилтэн	Баасанжавын Ганболд Зүүн-Хойд Азийн бүсийн төвийн тэргүүн	Шахбаз Хан Бээжин дэх төлөөлөгчийн газрын захирал	Халид Шарифи Сангийн тэргүүн
НҮБ-ХДХВ/ДОХ	НҮБ-ЮНСТАД	НҮБХХ	НҮБ-ГЭБГ	НҮБ-БОХ	НҮБ-АНДЭЗНК	НҮБ-БШУСБ	НҮБ-ХАС
Лаксман Перера НҮБ-ын Хабитат байгууллагын Япон улс дахь салбарын Хүний суурьшлын асуудал хариуцсан мэргэжилтэн	Эваристе Коуасси- Комлан Суурин төлөөлөгч	Стивен Б. Каргбо БНХАУ дахь Бүсийн төвийн тэргүүн бөгөөд БНАСАУ болон Монгол Улсыг хамааргач	Жереми Дуглас Зүүн Өмнөд Ази, Номхон далайн бүс нутаг дахь Суурин төлөөлөгч	Самина Кадвани Зүүн өмнөд Ази, Номхон далайн бүс нутаг дахь Улс орнууд хариуцсан газрын захирал	Дмитрий Фрицин Ази, Номхон далайн бүсийн хөтөлбөр хариуцсан менежер	Сара Книббс Бүс хариуцсан захирал	Др Сокорро Эскаланте Суурин төлөөлөгч
НҮБ-ХАБИТАТ	НҮБ-ХС	НҮБ-АУХБ	НҮБ-МБГХТА	НҮБ-ТУА	НҮБ-СДХ	НҮБ-ЭМЭГТЭЙЧҮҮД	ДЭМБ

# МОНГОЛ УЛС ДАХЬ НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАГЧ ТАЛУУД



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР



Улсын Их Хурал



THE WORLD BANK



European Commission



USAID  
FROM THE AMERICAN PEOPLE



GREEN CLIMATE FUND



gef  
GLOBAL ENVIRONMENT FACILITY  
INVESTING IN OUR PLANET



KOICA  
Korea International Cooperation Agency



THE GOVERNMENT OF THE GRAND DUCHY OF LUXEMBOURG



Gavi  
The Vaccine Alliance



Government of Japan



Global Affairs Canada  
Affaires mondiales Canada



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra  
  
Swiss Agency for Development and Cooperation SDC



Government of the Netherlands



Australian Government



UNITEL



ADAPTATION FUND



fedasil  
AGENCE FEDERALE POUR L'ACCUEIL DES DEMANDEURS D'ASILE



The Asia Foundation

# БҮЛЭГ 1

## МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

3.5 сая 

ХҮН АМЫН ТОО, 2023 ОНЫ БАЙДЛААР<sup>1</sup>

69% 

ХОТ СУУРИН ГАЗРЫН  
ХҮН АМ, 2022

31% 

ХӨДӨӨГИЙН ХҮН  
АМ, 2022

19 

1000 ХҮН АМД НОГДОХ  
ТӨРӨЛТИЙН ТҮВШИН,  
2023 ОНЫ БАЙДЛААР

26

ЭХИЙН ЭНДЭГДЭЛ<sup>2</sup>  
(100,000 АМЬД  
ТӨРӨЛТӨД НОГДОХ),  
2023 ОНЫ БАЙДЛААР

15

5 ХҮРТЭЛХ НАСНЫ  
ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ<sup>3</sup>  
(1000 АМЬД ТӨРӨЛТӨД),  
2023 ОНЫ БАЙДЛААР

0.741

ХҮНИЙ  
ХӨГЖЛИЙН ИНДЕКС<sup>4</sup>,  
НИЙТ 193 ОРНООС 96-Д,  
2022 ОНЫ БАЙДЛААР

0.297

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БУС  
БАЙДЛЫН ИНДЕКС<sup>5</sup>,  
НИЙТ 166 ОРНООС 72-Д,  
2022 ОНЫ БАЙДЛААР



<sup>1</sup> <https://www.1212.mn/en/statistic/file-library/view/73581389>

<sup>2</sup> <https://www.1212.mn/en/dissemination/72995930>

<sup>3</sup> <https://www.1212.mn/en/dissemination/72995930>

<sup>4</sup> <https://hdr.undp.org/data-center/specific-country-data#/countries/MNG>

<sup>5</sup> <https://hdr.undp.org/data-center/thematic-composite-indices/gender-inequality-index#/indicies/GII>



# 27.1%

ЯДУУРЛЫНТҮВШИН<sup>3</sup>,  
2023 ОНЫ БАЙДЛААР

# 0.53

ЭРХ ЗҮЙТ ЁС ИНДЕКС<sup>4</sup>,  
142 ОРНООС 64-Т,  
2023 ОНЫ БАЙДЛААР

# 33

АВЛИГЫН  
ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС<sup>5</sup>,  
НИЙТ 180 ОРНООС 121-Т,  
2023 ОНЫ БАЙДЛААР

# 0.7209

ЦАХИМ-ЗАСАГЛАЛЫН  
ХӨГЖЛИЙН ИНДЕКС<sup>6</sup>,  
НИЙТ 193 ОРНООС 74-Т,  
2022 ОНЫ БАЙДЛААР

Монгол Улсын эдийн засаг олон улсын геополитикийн нөхцөл байдал, далайд гарцгүйн сул тал зэргээс үл шалтгаалан 2023 онд 7 хувиар өсөж, чамгүй амжилт гаргалаа. Хэдийгээр өсөлт өндөр гарсан ч нийт эдийн засгийн уул уурхайн салбар, тэр дундаа нэг зах зээлээс хэт хамааралтай (нийт экспортын 91.4%, нийт уул уурхайн бүтээгдэхүүний экспортын 91.6% нь нэг зах зээлрүү гардаг) байдал хэвээр хадгалагдаж байгаа нь эдийн засгийн төрөлжилтийг эрчимжүүлэх шаардлагатай харуулж байна. Монгол Улс нь Цахим засаглалын хөгжлийн индекс-ээр дэлхийн улс орнуудын дунд 74-т эрэмбэлэгдэж байна. Түүнчлэн, Монгол Улс цахим худалдааг дэмжих, төрийн үйлчилгээг цахимжуулах (e-Mongolia 3.0), хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор хөдөө аж ахуйн салбарт цахим хөгжлийн шинэ хандлагуудыг нэвтрүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллаа.

Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Дэлхийн банкны судалгаагаар Монгол Улсын ядуурлын түвшин 2022 онд 27.1%-тай байгаа бол нийт хүн амын 7.3 хувь нь (2021 онд 243 мянган хүн) олон хэмжээст ядууралд өртсөн харин 15.5 хувь нь (2021 онд 519 мянган хүн) олон хэмжээст ядууралд өртөх эрсдэлтэй ангилалд багтаж байна. Дунд насны боловсролын түвшин болоод амьжиргааны түвшин доогуур, орон нутагт амьдардаг эрчүүд хөгжлөөс орхигдох магадлал хамгийн өндөртэй байгаа нь судалгаагаас харагдсан. Харин хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, дотооддоо шилжин суурьшигчид, хүүхдүүд болон орон гэргүй иргэд (үүнд

боловсролын түвшин бага, архины хамааралтай эсвэл, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон хорих байр болон асрамжийн газраас гарсан иргэд) хөгжлөөс орхигдох эрсдэлтэй бүлэгт багтаж байгаа юм.

Монгол Улс 2022 онд Жендерийн тэгш бус байдлын индексээр 72-д эрэмбэлэгдсэн. Монгол эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь амьдралынхаа аль нэг үед хүчирхийллийн ямар нэгэн хэлбэрт өртөж байгаа бөгөөд байнгын хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 31.2% нь дотны хамтрагчийнхаа зүгээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан тухай судалгааны тайланд өгүүлжээ. ҮСХ болон НҮБ-ын Хүн амын сан хамтран гэр бүлийн хүчирхийлэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсон ба бага насандаа хүчирхийлэлтэй орчинд өссөн эсвэл өртөж байсан эсэх нь насанд хүрсэн хойноо хүчирхийлэгч болох эрсдэлийг хамгийн ихээр нэмэгдүүлж байгаа бол гэр бүлийн эрүүл орчин тус эрсдэлийг бууруулах гол хүчин зүйл болдог байна. Залуучууд, өсвөр насны хүүхдүүд, нэн ялангуяа хамгийн эмзэг бүлгийн хүүхдүүд сургуулиас завсардах, ажилгүйдэл болоод сэтгэл зүйн хямралд өртөх эрсдэл өндөртэй байна. Монгол Улс залуучуудаа шаардлагатай ур чадвар, зохистой ажлын байраар хангаж, ажиллах хүчний бүхий л давхаргыг жигд ажлын байраар хангах тал дээр анхаарах шаардлагатай байна.

Бэлчээрийн даац хэтэрсэн, өвсний гарц муудсан, уур амьсгалын өөрчлөлт нэмэгдсэн зэрэг томоохон бэрхшээлүүд улс орны хэмжээнд тулгарсан хэвээр

байна. Цөлжилт газар нутгийн дийлэнх хэсэг нүүрлээд байгаа бөгөөд үүнд малын тоо толгой нэмэгдэж байгаа нь нөлөөлж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө хүчтэй мэдрэгдэж, зудын давтамж нэмэгдэж байгаа нь малчдын амьжиргаа, хүнсний аюулгүй байдалд хүндээр тусч байна. 2023 оны өвөл нийт нутгийн 90% нь зудын өндөр эрсдэлтэй бүсд багтаж байгаа бөгөөд энэ нь 190 мянган малчин өрхийн амьжиргаанд шууд нөлөөлөхөөр байгаа юм. Монгол Улс 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад оруулах Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтоо (ҮТХН) 27.2% (нөхцөлт) буюу 22.7% (нөхцөлт бус) хэмээн ахиулан шинэчлэн тодорхойлсон. Ийнхүү, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэхэд жил бүр ДНБ-ийхээ нэг хувийг зарцуулах үүрэг хүлээсэн бөгөөд үүнд ойролцоогоор 11.5 тэрбум ам.доллар шаардлагатай байна. 2023 онд Монгол Улсын улс төрийн болоод засаглалын хүрээнд өрнөсөн гол үйл явдлууд нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан, сонгууль, улс төрийн нам, боловсролын тогтолцоотой холбоотой хуулиудыг шинэчлэн баталсан, авилгалын талаарх өрнөсөн дуулиан зэрэг байлаа. Тухайлбал, сонгуулийн тогтолцоонд өөрчлөлт оруулах, улс төрд нэр дэвшигчдийн дунд хүйсийн квот тогтоох, намуудын санхүүжилтийг ил тод болгох зэрэг өөрчлөлтүүд нь 2024 оны УИХ-ын сонгуульд тусгалаа олох юм.

Трансперенси интернэшнл байгууллагаас зарладаг Авлигын төсөөллийн индексээр Монгол Улс нь дэлхийн улс орнуудын дунд 121-рт жагсаж байна. Монгол Улсын

Засгийн газар 2023 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж, “Таван-Ш ажиллагаа”-г явуулахаа мэдэгдсэн. Үүнд 1) авлигачдыг мэдээлэх шүгэл ажиллагаа, 2) төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах шил ажиллагаа, 3) төрийн албанд хууль бусаар томилогдсон хүмүүсийг илрүүлэх шүүр ажиллагаа, 4) гадаад улс руу оргон зайлсан авлигын гэмт хэрэгтнүүдийг эргүүлэн авчирч хариуцлага хүлээлгэх шувуу ажиллагаа, 5) хууль бус хөрөнгийг илрүүлэн шилжүүлэн авчрах ажиллагаа зэрэг орсон.

Хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа тасралтгүй нэмэгдэж, сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд хөдөө, орон нутгаас хотруу шилжих хөдөлгөөн ихэссээр ирсэн нь Улаанбаатар хотын ачааллыг маш ихээр нэмэгдүүлээд байна. Засгийн газраас үр дүнд суурилсан татвар болон хөрөнгө оруулалтын бодлогын арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлэхэд бүс нутгийн онцлог, өгөөж өндөртэй салбаруудыг нарийн судалж, зураглал гаргах шаардлагатай байна. Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг бүс нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжих жил болгон зарлаж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж эхлээд байна.

<sup>1</sup> <https://www.1212.mn/en/statistic/file-library/view/76105511>

<sup>2</sup> <https://www.1212.mn/en/statistic/file-library/view/73581389>

<sup>3</sup> [https://1212.mn/en/statistic/statcate/573066/table-view/DT\\_NSO\\_1900\\_007V12](https://1212.mn/en/statistic/statcate/573066/table-view/DT_NSO_1900_007V12)

<sup>4</sup> <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/global/2023/Mongolia/>

<sup>5</sup> <https://www.transparency.org/en/cpi/2023/index/mng>

<sup>6</sup> <https://publicadministration.un.org/egovkb/en-us/Data/Country-Information/id/113-Mongolia>

## БҮЛЭГ 2

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ЗАМААР ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН  
ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТУУДЫГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХЭД НҮБ-ЫН  
ХӨГЖЛИЙН СИСТЕМЭЭС  
ҮЗҮҮЛЖ БҮЙ ДЭМЖЛЭГ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ  
ҮЙЛДЛЭЭРЭЭ НЭГДЬЕ!

НАГДСАН ҮНДЭСНИЙ  
БАЙГУУЛАГА  
МОНГОЛ УЛС

UNITE TO ACT

1 АДУУРЫГ  
УСТАХ

2 ӨЛСГӨЛӨНГ  
УСТАХ

3 ЗРҮҮЛ МЭНДИЙГ  
ДЭМЖИХ

4 ЧАНАРТАЙ  
БОЛОВСРОЛЫГ  
ДЭМЖИХ

5 ЖЕНДЕРИЙН  
ЭРХ ТЭГШ  
БАЙДЛЫГ ХАНГАХ

6 БАТАЛГААТ УНДНЫ УС,  
АРИУН ЦЭВРИЙН  
БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ

7 СӨНГӨГДӨХ ЭРЧИМ  
ХҮНИЙГ  
ХӨВӨРӨХ

8 ЭДИЙН ЗАСГИЙН  
ӨСӨЛТ ЗОХИСТОЙ  
ХӨДӨЛМӨРИЙГ ДЭМЖИХ

9 АЖ ҮЙЛДЭЭР,  
ИННОВАЦ ДЭД  
ВҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

10 ТЭГШ БҮС  
БАЙДЛЫГ  
БУУРУУЛАХ

11 ЗЭЛТЭЙ ХОТ,  
ИРГЭДИЙН  
ОРОЛЦООГ ДЭМЖИХ

12 ХАРИУЦЛАГАТАЙ  
ҮЙЛДВЭРЛЭЛ,  
ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ

13 ҮҮР АМЬСГАЛЫН  
БОРЧЛОЛТИЙН  
НӨЛӨГ БУУРУУЛАХ

14 ДАЛАЙ ТЭМГИСИЙН  
НӨВЦИЙГ  
ХАМГААЛАХ

15 ХУУРАЙ ГАЗРЫН  
ЭКО СИСТЕМНИЙГ  
ХАМГААЛАХ

16 ЭНХ ТАЙВАН,  
ШУДАРГА ЕСЫГ  
ЦОГЦЛООХ

17 ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ  
ТҮНШЛЭЛИЙГ  
БЭХЖҮҮЛЭХ

## 2.1 НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2023 он Монгол Улс дахь НҮБ-ын хувьд (1) Хүний хөгжил, сайн сайхан байдал, (2) Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлт, (3) Хүн төвтэй засаглал, эрх зүйт ёс, хүний эрх гэсэн стратегийн гурван тэргүүлэх чиглэл бүхий НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээг (2023-2027) хэрэгжүүлж эхэлсэн анхны жил байснаараа онцлог байлаа. Эдгээр гурван тэргүүлэх чиглэл нь дөрвөн үр дүнгийн зорилт болоод арван зургаан үр дүнд хуваагдана.

НҮБ-аас Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх зорилтуудыг биелүүлэхэд хэрхэн хувь нэмэр оруулж буйгаа үндэсний хэмжээний 22 болон үр дүнгийн 38 үзүүлэлтээр хэмжиж байна. Тус үзүүлэлтүүд (хавсралтаас дэлгэрэнгүй харах боломжтой) нь НҮБ-аас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд нэгдсэн байдлаар хэрхэн Монгол Улсын хөгжилд хувь нэмэр оруулж буйг харуулах гол хэмжүүр үзүүлэлтүүд билээ. Бүлэг болох "2.2 НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээний тэргүүлэх чиглэл, үр дүнгийн зорилт, үр дүн" -д төсөл, хөтөлбөрүүдийн гаргасан амжилт, үр дүнг товч түүх, тоо мэдээллээр баяжуулан хүргэх болно.

Тайлант хугацаанд НҮБ-ын системийн нийт 23 байгууллага (суурин 9, суурин бус 14) нь стратегийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд үндэсний болон орон нутгийн хэмжээнд, иргэдийн гарт хүрч, хөрсөнд буусан энгийн төслөөс эхлээд улс орны стратеги, бодлогын түвшинд нөлөөлөхүйц нийтдээ 158 дэд үр дүнгийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Монгол дахь НҮБ өнгөрсөн онд нийт 51.5 сая ам.долларын санхүүжилтийг татан төвлөрүүлж, 44.8 сая ам.долларыг зарцуулж, 87.0%-ийн зарцуулалтын гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 1: Тэргүүлэх чиглэл бүрээр санхүүгийн мэдээлэл (2023 он, сая ам.доллар)

Тэргүүлэх чиглэл	Шаардлагатай	Татан төвлөрүүлсэн	Зарцуулалт
Хүний хөгжил, сайн сайхан байдал,	17.73	16.70	14.94
Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлт	26.58	27.21	22.80
Хүн төвтэй засаглал, эрх зүйт ёс, хүний эрх	7.66	7.58	7.04
Нийт	51.97	51.49	44.78

Эх сурвалж: UN-info



Монгол Улс дахь НҮБ нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэх үйл хэргийг дэмжих, тэр дундаа ТХЗ 3 (Эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих), ТХЗ 9 (Үйлдвэрлэл, инновац, дэд бүтцийг хөгжүүлэх), ТХЗ 13 (Уур амьсгалын

өөрчлөлтийн сөрөг нөлөөг багасгах), ТХЗ 5 (Жендерийн эрх тэгш байдлыг хангах), ТХЗ 15 (Хуурай газрын экосистемийг хамгаалах) зэрэг зорилгуудыг хэрэгжүүлэхэд илүү хүчин чармайлт гарган ажиллаа.

## Монгол Улсын Үндэсний сайн дурын хоёрдугаар илтгэл болон Тогтвортой хөгжлийн төлөөх үндэсний чуулган

НҮБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улс нь Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн хоёр дахь удаагийн Үндэсний сайн дурын илтгэлээ бэлтгэж 2023 оны 7-р сард болсон НҮБ-ын Тогтвортой хөгжлийн улс төрийн дээд түвшний чуулга уулзалтад танилцуулсан билээ. Энэхүү илтгэл нь Монгол Улсын ТХЗ-ын хэрэгжилтийн явц, бодлого, хүчин чармайлтууд, эхний илтгэлээс гарсан зөвлөмжийн биелэлт зэрэгт үнэлгээ өгсний зэрэгцээ КОВИД-19 цар тахлын нөлөө, геополитикийн зөрчил мөргөлдөөний нөлөөллийг ч мөн судалсан. Түүнчлэн анхаарлаас гадна орхигдох эрсдэлтэй байгаа хүн амын бүлгүүдийг тодорхойлох, тогтвортой байдалд нөлөөлж буй бүс нутгийн хөгжлийн ялгааг судалсан байна.



Тогтвортой хөгжлийн Үндэсний чуулганы хэлэлцүүлэгт оролцсон панелистүүд © НҮБ-ын СЗГ

Монгол Улс дахь НҮБ нь Засгийн газартай хамтран Тогтвортой хөгжлийн төлөөх үндэсний чуулга уулзалтыг 2023 оны 9-р сарын 7-нд зохион байгуулсан ба тус чуулганаар Монгол Улсын ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгах үндэсний үүрэг амлалтаа нийгмийн бүхий л бүлгүүд, хөгжлийн түншүүдийн төлөөлөл болох 220 гаруй төлөөлөгчийг оролцуулан хэлэлцэж, эцэслэн тодорхойлсон билээ.

Тогтвортой хөгжлийн төлөөх үндэсний чуулган нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүчин чармайлтыг эрчимжүүлэх Арван хоёр (12) Хурдасгуур тэргүүлэх чиглэлийг тодорхойлж ТХЗ-ыг хэрэгжүүлэх зорилтуудаа ахиулан шинэчлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Үүний үргэлжлэл болгон чуулганаар тодорхойлсон Арван хоёр хурдасгуур тэргүүлэх чиглэлийн замын зураглалыг боловсруулах зорилгоор төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид болон бусад оролцогч талуудыг урьж оролцуулсан олон удаагийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулахад НҮБ-аас Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яаманд дэмжлэг үзүүлэн ажилсан билээ. Эдгээр хэлэлцүүлгийн үр дүн нь дээр өгүүлсэн ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх 12 үндэсний хурдасгуурын замын зураглалыг боловсруулах үндэс суурь болох юм.



## 2.2 НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээний тэргүүлэх чиглэл, үр дүнгийн зорилт, үр дүн

## СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1: ХҮНИЙ ХӨГЖИЛ, САЙН САЙХАН БАЙДАЛ



НҮБ-ын Суурин зохицуулагч Тапан Мишра Монголын Дауны Холбооны дэргэдэх кафед зочилж, даунтай залуустай цагийг хамт өнгөрүүлсэн нь. © НҮБ-ын СЗГ

2023 онд стратегийн нэгдүгээр тэргүүлэх чиглэлийн хүрээнд НҮБ-ын системийн 11 байгууллага хэрэгжүүлэгчтүншүүдтэйгээ хамтран үндэсний хэмжээнд 51 дэд үр дүнгийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, 14.9 сая ам.долларын санхүүжилтийг олгосон байна.

**Үр дүнгийн зорилт 1: 2027 он гэхэд хот, хөдөөгийн иргэн бүр, ялангуяа нэн эмзэг болон орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд нь өөрсдийн нөөц боломжийг бүрэн дүүрэн, эрх тэгш ашиглаж, хүний эрхэд суурилсан, хүртээмжтэй, жендерийн мэдрэмжтэй, цочролд тэсвэртэй эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, нийгмийн хамгаалал, ус, ариун цэврийн байгууламжийн болоод бусад үйлчилгээний үр шимийг хүртэнэ.**

Өнгөрсөн онд боловсролын хүртээмжийг сайжруулах тэргүүтэй боловсролын салбарт тулгамдаж байгаа олон чухал асуудлыг шийдвэрлэх зорилгоор Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурал (УИХ) баталлаа. Түүнчлэн УИХ 2024 оны 1-р сарын 11-ний өдөр Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан нь иргэншил болоод оршин суугаа газрыг үл харгалзан хүүхэд бүрт хүрэх нөхцөлийг бүрдүүлсэн. НҮБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улс нь Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгох, бага насны

хүүхдийн хөгжил, өсвөр үеийнхэнд чиглэсэн ээлтэй үйлчилгээ, амны хөндийн эрүүл ахуй, шүдний эмчилгээ зэрэг үйлчилгээг цогцоор хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргаж ажилсан ба энэ нь хүн амын нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хамрах хүрээ, уялдаа, хүртээмж, тэгш шударга байдал, чанарыг сайжруулахад чиглэж байна.

Хамтын ажиллагааны хүрээ хэрэгжиж эхэлсэн эхний жилд үр дүнгийн (үндэсний) шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтэд огцом ахиц гараагүй, эхийн эндэгдэл 4 пунктээр буурснаас бусдаар үзүүлэлтүүд суурь түвшинтэйгээ ойролцоо хэвээр байна. Тиймээс эдгээр шинэчлэгдсэн хууль, бодлогыг хөрсөнд буулгаж, үр дүнтэй хэрэгжүүлэх нь нэн чухал бөгөөд тулгамдсан асуудал болж байна. Түүнчлэн, тулгамдаж буй гол асуудлыг шийдвэрлэх хийгээд шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь тууштай хэрэгжүүлэхийн тулд улс төрийн хүсэл зориг, оролцогч талуудын оролцоог урт хугацаанд тогтвортой байлгах нь чухал юм. Цаашлаад, хяналт шинжилгээ, үнэлгээний бат бөх тогтолцоог бэхжүүлэх замаар хуулийн хэрэгжилтийг хангахад анхаарч, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг тооцон хүн амд зохих үйлчилгээг цаг алдалгүй хүргэх шинэлэг арга техникийг (инновац) нэвтрүүлэх, хүрсэн ололт амжилтын



Хүний папиллома вирусын эсрэг вакциныг заавал хийх дархлаажуулалтын жагсаалтанд оруулаад байна.



**250,000**

“Эрүүл насжилт” эрүүл мэндийн хөтөлбөрт 250,000 өндөр настан хамрагдан үр шимийг нь хүртээд байна.



**Үр дүн 1.1 Жендэрийн мэдрэмжтэй, цочролд тэсвэртэй, хүртээмжтэй, хямд төсөр, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ (бие махбодын, сэтгэцийн, бэлгийн болон нөхөн үржихүйн), хоол тэжээлийн болон ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг хүн бүрт хүргэх эрүүл мэндийн нэгдсэн тогтолцоог дэмжих чадавч бэхэжсэн байна.**

2023 онд НҮБ-ын систем нь Монгол Улсын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн i) Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төвүүдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт зэрэг үндсэн элементүүдийг багтаасан Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний журмыг шинэчлэн батлах, ii) 2023-2025 онд мэс заслын аюулгүй байдлыг хангах үндэсний төлөвлөгөөг батлах, iii) Эрүүл шүд үндэсний хөтөлбөрийг батлах тухай тогтоол (2023 оны 8-р сард батлагдсан), iv) Боловсролын тухай хуульд 28.10 заалтыг тусгаж, сурагчдын эрүүл мэндийн хяналтын тогтолцоог сургуулиудад түшиглэн цогцоор нь байгуулах, v) Монгол Улсын Засгийн газрын “Иргэдийн эрүүл

мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 321 дүгээр тогтоолыг 2024-2027 онд хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах зэрэг олон арга хэмжээнд дэмжлэг үзүүлж ажиллаа.

НҮБ нь Хүний папиллома вирус (ХПВ/HPV)-ын эсрэг шинэ вакциныг улс орон даяар нэвтрүүлэх, улмаар тэдгээрийг үндэсний дархлаажуулалтын жагсаалтад оруулах чиглэлээр Эрүүл мэндийн яаманд дэмжлэг үзүүлж ирсэн. Үүний үр дүнд УИХ-ын 2023 оны 10-р сарын 27-ны өдөр баталсан Дархлаажуулалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакциныг нэмэлтээр зайлшгүй хийх дархлаажуулалтын жагсаалтад оруулсан. Түүнчлэн НҮБ-ын зүгээс нийгмийн эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэхийг ухуулан дэмжиж, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль (2024 оны 1-р сарын 12-нд батлагдсан)-ийн төсөлд санал, зөвлөмжөө хүргүүлсэн билээ. Ингэснээр гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө, үйлчилгээ зэрэг нийгмийн эрүүл мэндийн бүх төрлийн үйлчилгээг улсын төсөв, эрүүл мэндийн даатгалд хамруулж, иргэдийн халааснаас гарах шууд зардлыг багасгах томоохон өөрчлөлтийг авчирсан болно. Мөн амны хөндийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр, хүнсний аюулгүй байдлын менежментийн олон улсын стандартыг нэвтрүүлэх, УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд байгаа тамхи, элсэн чихрийн татварын тухай хууль зэрэг үндэсний хэмжээнд эрүүл мэндийн талаарх хууль зүйн орчинд томоохон ахиц дэвшил гарахад НҮБ-ын системийн



## Цахим хөгжлөөс үүдсэн ялгааг арилгахаар алслагдсан бүс нутгийн хүүхдүүдийн цахим ур чадварыг хөгжүүлэх нь.



Программ хангамжийн инженер болж, код бичиж, программ зохиох мөрөөдөлтэй 15 настай А. Бүжмаа охинтой танилц. Тэр бол Хөвсгөл аймгийн Ханх сумын сургуулийн сурагч бөгөөд сургуулийнхаа Мэдээлэл технологийн клубт хамрагддаг цөөхөн охидын нэг юм.

НҮБ-ын Хүүхдийн Сангаас ЕБС-иудын сурагчдын хичээлээс гадуурх үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Монголд анх удаа ICT клубуудыг байгуулж байна. Цар тахлын үед Монгол орон даяар олон хүүхэд, тэр тусмаа Ханх зэрэг алслагдсан сум, орон нутгийн хүүхдүүд технологийн боломжгүйгээс шалтгаалж зайны сургалтад хамрагдаж чадахгүй байв. Хүүхдэд цахим ур чадвар эзэмшүүлэх цаашлаад бүх хүүхдэд тэгш боловсрол олгох зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сан нь үүрэн холбооны тэргүүлэгч оператор Мобикомтой хамтран “Smart Education” санаачилгыг хэрэгжүүлж байна. Энэхүү санаачилгын хүрээнд Мобиком нь найман сургуульд цахим анги байгуулсан.

НҮБ-ын Хүүхдийн сан нь “Ази тивийн сургуулиуд” хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн багш, сурагчдад цахим бичиг үсгийн боловсрол, хосолмол заах арга зүй, технологийн төхөөрөмж ашиглах, цахим контент бүтээх, хөгжүүлэх зэрэг сургалтуудыг явуулж байна.



байгууллагуудын техникийн туслалцаа, дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэсэн.

Залуучуудын сайн сайхан байдал, бүтээмжид хувь нэмрээ оруулах институцийн болон дэд бүтцийн чадавхыг бэхжүүлэхэд НҮБ-ын системийн байгууллагууд дэмжлэг үзүүлээ. Тухайлбал, нийслэлийн төрийн өмчит сургуулийн 200 гаруй эмчийн дунд сургалт болоод 363,377 өсвөр үеийнхэнд зориулан эрүүл мэндийн чиглэлээр сургалт зохион байгуулсан. НҮБ-аас Дархлаажуулалт болон улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний талаар сургалт явуулж эрүүл мэндийн ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх, вируст гепатит, ХДХВ, БЗДХ-ын тандалтын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Түүнчлэн, нотолгоонд суурилсан байдлаар ХДХВ-ийн халдвартай тэмцэх болон хяналт шинжилгээний төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх ажлыг иргэний нийгмийн байгууллага, олон нийтийг хамруулан зохион байгуулж байна. Цаашлаад, 250 мянган ахмад настны амьдралын чанарыг дээшлүүлэхэд нэмэр оруулах зорилготой Эрүүл насжилтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, Эрүүл мэндийн салбарын манлайллыг бэхжүүлэхэд НҮБ-ын системийн байгууллагууд дэмжлэг үзүүлээ.

**86.6%**

Бага насны хүүхдийн боловсролын хүртээмж 83.0%-аас 86.6% болж өсөв.



**46,207**

Ур чадвар хөгжүүлэх болон насан туршийн боловсролын хөтөлбөрт 46,207 иргэн хамрагдав.



**Үр дүн 1.2 Боловсролын тогтолцоо, боловсролын байгууллагууд нь бага насны хүүхдийн боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол, амьдрах ухаан, бэлгийн цогц боловсрол зэрэг боловсролын бүхий л үйлчилгээнд ялангуяа онцгой байдлын үед эмзэг бүлгийн хүүхдүүдийг оролцуулан нийт хүүхэд, залуучуудын хүртээмжтэй, тэгш хамруулан сургах, сургуулиас хөдөлмөрийн зах зээлд шилжих боломжийг бүрдүүлэх түвшинд хүрч чадавхжсан байна.**



НҮБ-ын системийн байгууллагуудын оролцогч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, мэдээлэл сурталчилгаа, техникийн дэмжлэгийг тасралтгүй үзүүлж ирсний үр дүнд Хувьсан буй боловсрол дээд хэмжээний чуулганы уриалгын дагуу Монгол Улс үндэсний үүрэг амлалтаа хэрэгжүүлэх замын зураглалыг боловсруулсан. Энэ нь засгийн газрын ойрын гурван жилд хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлд тусгалаа олохын зэрэгцээ шинээр батлагдсан Боловсролын багц хуулийн хэрэгжилтийг хангах чухал арга хэрэгсэл болох юм. Түүнчлэн, НҮБ-ын зүгээс холбогдох байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээ хийх замаар нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажиллаа. Үүний үр дүнд НҮБ-ын үндсэн зарчимд бүрэн нийцсэн үндэсний хэмжээний сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үзэл баримтлалын хүрээг боловсруулж, баталсан юм. НҮБ-ын дэмжлэгтэйгээр төсөл хөтөлбөрүүд, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсний үр дүнд орхигдох эрсдэлтэй хүүхдүүдэд хүрч үйлчлэх боловсролын үйлчилгээний чанар сайжирч, төв, орон нутгийн түвшинд институцийн болоод хүний нөөцийн чадавх бэхжиж байна. Ялангуяа гэр бүлд суурилсан бага насны хүүхдийн боловсролын шинэлэг, өвөрмөц хөтөлбөрийг хэрэгжүүлж бага насны хүүхдийн боловсролын хүртээмжийг 83-с 86.6 хувь хүртэл сайжруулахад НҮБ-ын техникийн туслалцаа чухал үүрэг гүйцэтгэсэн. НҮБ-ын дэмжлэгтэйгээр 31 мастер сургагч багшийг сургаж бэлтгэсэн. Эдгээр сургагч багш нар бусад аймаг, дүүргийн эрүүл мэндийн боловсролын 231 багшийг сургаж ур чадварыг нь дээшлүүллээ. Цаашлаад, НҮБ-ын дэмжлэгтэйгээр сургуулийн өмнөх болон бага ангийн 7,100 гаруй хүүхдийг сурч боловсрох, суралцах суурь ур чадварыг нь төлөвшүүлэхэд чиглэсэн төслийг хэрэгжүүллээ.

Боловсролын систем дэх дижитал хувьсал өөрчлөлтийн талаарх төсөл хөтөлбөрүүд үргэлжлэн хэрэгжиж байна. Бага боловсролын сургалтын нэмэлт 20 интерактив агуулгыг боловсруулж, багш нарын дижитал ур чадварыг сайжруулж, эдгээр сургалтуудын ашиг тусыг 1076 багш шууд, бага боловсролын 5,944 сурагчид шууд бусаар хүртсэн. Мөн үндэсний хэмжээний боловсролын платформ дээр бэлгийн боловсролын талаарх нэмэлт 60 шинэ агуулгыг байршууллаа.

**14,299**

Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хууль эрх зүй/хууль сахиулах хүрээнд шаардлагатай тусламж үйлчилгээг 14,299 хүүхдэд хүргээд байна.



**2,900**  
Нийгмийн тусламж үйлчилгээ хүргэх ажлыг боловсронгуй болгох үүднээс төрийн үйлчилгээний тэргүүн шугамд ажилладаг 2,900 ажилтныг чадавхыг бэхжүүлэв.



**Үр дүн 1.3 Нийгмийн болон хүүхэд хамгааллын бодлого, тогтолцоо (нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөрийн зах зээлийн хөтөлбөрүүд) нь хүн бүрийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд эрх тэгш хамруулж, хямрал цочролд тэсвэртэй, тогтвортой хөгжиж хүн амын эмзэг хэсгийг найдвартай хамгаалах чадавхтай болно.**

НҮБ нь нийгмийн даатгалын шинэчлэлийн талаарх мэдээлэл сурталчилгаа, бодлогын хэлэлцүүлгийг оролцогч талуудын дунд өрнүүлсээр байна. Нийгмийн даатгалын харилцааг зохицуулах хуультай болох, Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөж төлүүлэхийг хориглох, Нийгмийн даатгалын шимтгэлийг Засгийн газраас олгож буй татаасаас суутган тооцох зэрэг НҮБ-аас хүргүүлсэн гол зөвлөмжүүдийн зарим хэсгийг тусгасан Нийгмийн даатгалын тухай дөрвөн хуулийг 2023 оны 7-р сард УИХ баталсан. НҮБ-ын зөвлөмж, техникийн туслалцааны дагуу эрүүл мэндийн даатгалын тогтолцоог нэмэлт үйлчилгээгээр өргөжүүлсний үр дүнд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээг шат шатны эрүүл мэндийн төвүүд эрүүл мэндийн даатгалаар үнэ төлбөргүй үзүүлж эхэлсэн.

2024 оны 1-р сард батлагдсан Хүүхэд хамгааллын тухай шинэ хуулийн төслийг боловсруулахад НҮБ-ын системийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр явуулсан судалгаа, үнэлгээний тайланг өргөнөөр ашигласан. Энэ хуулиар “хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх” гэсэн хуучин баримталж ирсэн хүүхэд хамгааллын зарчмаа өөрчилж “хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлж, хамгаалах” гэсэн шинэ зарчмыг мөрдөх болсноор иргэн, иргэний харьяалалгүй, харьяалал тодорхой бус зэргээс үл хамааран Монгол Улсад амьдарч байгаа хүүхэд нэг бүр, түүнчлэн хилийн чанадад амьдарч байгаа монгол хүүхэд нэг бүрд хамаарахаар хуульчилж өгсөн. Түүнчлэн, энэ хуулиар хүүхэд хамгааллын үйл ажиллагааны менежмент, мэдээлэл цуглуулах, улсын болон орон нутгийн төсвөөс хүүхэд хамгаалал, хүүхэд асрах, удаан хугацаагаар хүүхэд асран хүмүүжүүлэх үйлчилгээ, гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын үйлчилгээ, хууль эрх зүйн туслалцаа зэрэгт зарцуулах хөрөнгө зэрэг асуудлын хууль эрх зүйн орчныг баталгаажуулсан.

Үйлчилгээний өртөг зардлыг тооцох, хүний эрхэд суурилсан зорилт, үр дүнг тодорхойлох чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн НҮБ-ын дэмжлэгийн үр дүнд 2023 онд 8 тэрбум төгрөг байсан хүүхэд хамгааллын төсөв 2024 онд 14 тэрбум төгрөг болж нэмэгдсэн.

Зөвхөн 2023 онд хүчирхийлэл, мөлжлөг, доромжлол, хайхрамжгүй байдалд өртсөн 14,299 хүүхэд НҮБ-ын дэмжлэгтэй төслүүдээс нийгэм, эрүүл мэнд, эрх зүйн туслалцаа авсан байна.

НҮБ нь Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, шилжих хөдөлгөөний урсгалыг зохицуулах, хөдөөнөөс хот руу чиглэсэн хяналтгүй шилжилт хөдөлгөөний сөрөг үр дагаврыг бууруулах, хот суурин газарт шилжин ирэгсдийн амьжиргааг сайжруулахад чиглэсэн бодлого, арга зүйн дэмжлэгийг хотын захиргаа, нийгмийн үйлчилгээний байгууллагууд, цагдаагийн байгууллагуудад үзүүлж байна. Энэ хүрээнд Улаанбаатар хотын Шилжилт хөдөлгөөний бодлогын төслийг боловсруулах, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага нь Нийслэлийн цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран Монгол Улсын хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг олж илрүүлэх, шилжүүлэх, тусламж үзүүлэх Түр хамгаалах байр ажиллуулах журмыг боловсруулж турших, хүн төвтэй, цагаач иргэдэд ээлтэй нийгмийн үйлчилгээ үзүүлэх зааврыг боловсруулах зэрэг ажлуудыг хийж байна.

**79,000**

Охид сургуулийнхаа “Охидын булан”-гаар дамжуулан сарын тэмдгийн эрүүл ахуйн талаар мэдлэг мэдээлэлтэй болсон.



**71,213**

Нийт 71,213 иргэд аюулгүй ундны ус болон ариун цэврийн үйлчилгээгээр хангагдаад байна.



**Үр дүн 1.4: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, жендэрийн мэдрэмжтэй, хүн бүрт хүртээмж тэй, хямд төсөр, чанартай ундны ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн үйлчилгээг хүн бүрт хүргэх хүчин чадалтай болно.**





## Залуучуудын дуу хоолой: Хүртээмжтэй нөхөн үржихүйн боловсролыг хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад хүргэх нь.

“Энэ сэдвээр ярилцахад надад цэрвэх, зовох зүйлгүй, хэвийн асуудал гэж бодож байна” гэж Адъяа НҮБ-ын Хүн амын сангийнхантай уулзахдаа ярьлаа. Адъяа бол Ерөний боловсролын сургуулийн (ЕБС) хичээлийн хөтөлбөрөөр дамжуулан насны онцлогтоо тохирсон бэлгийн цогц боловсрол авч буй олон мянган өсвөр насныхны нэг юм. Гэвч Адъяа үе тэнгийнхнээсээ ялгаатай нь харааны бэрхшээлтэй. “[Эдгээр хичээлүүд] надад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээний талаар гэр бүл болон эрүүл мэндийн зөвлөх ажилтнуудтай илэн далангүй ярилцахад минь тусалсан.”

Адъяа шиг олон Монгол залуучууд бэлгийн цогц боловсрол эзэмшихэд ихээхэн бэрхшээлтэй тулгардаг байсан юм. Тэгвэл НҮБ-ын Хүн амын сангаас ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран 2019 онд эрүүл мэндийн боловсролыг ЕБС-ийн хөтөлбөрт бие даасан хичээл болгон шинээр оруулж, хичээлийн агуулгыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилсэн юм. Үүний үр дүнд өнөөдөр бүх ЕБС-иуд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зэрэг насны онцлогт тохирсон сэдвээр суралцаж байна.

Гэсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй оюутан, сурагчдын хувьд сургалтын нөөц, хэрэглэгдэхүүн хомс хэвээр байв. НҮБ-ын Хүн амын сангийн хүртээмжтэй бэлгийн цогц боловсролыг дэмжин ажилласан нь 17 настай сонголын бэрхшээлтэй Билгүүнд шиг олон залуусын амьдрал, зан үйлд өөрчлөлт авчирчээ. НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын тусгай хэрэгцээт сургуулиуд болох 116 болон 29-р сургуульд Эрүүл мэндийн боловсролын кабинетуудыг байгуулж, багш, сурагчдад энэ сэдвийг илүү сайн ойлгож, харилцан ойлголцох боломжийг бүрдүүлсэн юм.

Билгүүн энэ талаар ярихдаа “Би бэлгийн эрүүл мэндийн талаар олон буруу ойлголттой байснаа олж мэдэж, эрүүл зан үйлийг амьдралдаа хэвшүүлэх талаар олон зүйл сурсандаа баяртай байна. Би сурсан зүйлсийнхээ ачаар өөрийгөө хамгаалж, илүү сайн сонголт хийх итгэлтэй боллоо” гэсэн юм.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсад ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулах орон нутгийн чадавх бэхжиж тогтвортой байдал сайжирснаар 2023 онд 71,213 хүн аюулгүй ундны ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ авах боломжтой болж, ТХЗ 6.1, 6.2 зорилтод хүрэх замыг хурдасгахад хувь нэмэр орууллаа.

Түүнчлэн, төрийн өмчийн 161 сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийг ундны ус сав/шүүлтүүр суурилуулж тоноглох, сургууль дотор ариун цэврийн өрөө, гар угаалгын өрөөг шинэчлэн байгуулах, бохир ус цэвэрлэх байгууламжийг суурилуулах зэрэг ажлууд хийгдсэн. Мөн сургуулиуд дээр охидын сарын тэмдгийн үеийн эрүүл ахуй, ариун цэврийг хадгалах зорилгоор “Охидын булан” байгуулсан нь 79 мянган хүүхдэд тус дэм болж байна. Улаанбаатар хотын хэмжээнд хот орчмын 2,075 өрх уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, жендэрийн мэдрэмжтэй ариун цэврийн байгууламжтай болсон. Байгальд ээлтэй усалгааны системийг хөгжүүлэх, Монгол орны хувьсан өөрчлөгдөж байгаа байгаль орчны онцлогийг тооцсон цаг уурын үзүүлэлт, ургамалжилтын бүрхэвчийн туршилтын судалгааг явуулахад НҮБ техникийн тусалцаа үзүүлэн ажиллаа.

**580**  
Хоол, шим тэжээлийн дутагдалтай 580 хүүхдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлээд байна.



**362,860**  
Шим тэжээл, эрдэс, амин дэмийн дутагдлаас сэргийлэх хөтөлбөрт 362,860 иргэн хамрагдан үр шим хүртлээ.



**Үр дүн 1.5 Хүн амын эмзэг хэсэгт онцгой анхаарал хандуулахын зэрэгцээ хүн бүр шим тэжээллэг, эрүүл хоол хүнсийг зохистой түвшинд хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах, дэмжих чадавх бэхжсэн байна.**

Өсөн нэмэгдэж буй илүүдэл жин, таргалалтын эсрэг тэмцэх зорилгоор УИХ-ын 2024 оны хаврын чуулганд өргөн мэдүүлэхээр төлөвлөж байгаа Элсэн чихрийн импортын татвар болон Зар сурталчилгааны тухай хуулийн төслийг боловсруулахад НҮБ-ын техникийн тусалцаа чухал үүрэг гүйцэтгэсэн. НҮБ-ын дэмжлэгтэйгээр Хүнсний аюулгүй байдлын олон улсын таван (5) кодекс стандартыг Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) баталж, үндэсний стандартад оруулсан. Мөн амьдрах орчин, амьтан, хүний эрүүл мэндийг хамарсан Нянгийн эсрэг эсэргүүцлийг цогцоор нь шийдвэрлэх зорилгоор Нянгийн эсрэг эсэргүүцлийн (AMR) 2023-2025 оны Үйл ажиллагааны төлөвлөгөө

боловсруулахад НҮБ дэмжлэг үзүүлсэн нь энэ төрлийн анхны албан ёсны гурван талт хамтын ажиллагааны төсөл болж байна. Түүнчлэн “Сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн үйлчилгээний шаардлага” үндэсний стандартыг СХЗГ боловсруулан баталсан. Шинээр нэвтрүүлсэн энэ стандартын дагуу нийт сургууль, дотуур байр, цэцэрлэгүүд нь хүүхдэд зориулсан аюулгүй, шим тэжээллэг хүнсийг боловсруулж, үйлчлэхдээ тавигдах стандартыг бүрэн хангасан байх үүрэг хүлээх юм.

Найман аймаг, хоёр дүүргийн 1,000 гаруй эрүүл мэндийн ажилтнуудад хоол тэжээлийн зөвлөгөө өгөх, ур чадвараа дээшлүүлэхэд нь НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн. Түүнчлэн НҮБ-ын дэмжлэгтэйгээр хүн, мал эмнэлэг, хүнсний салбарын үндэсний лабораторийн байцаагч нарын мэргэжлийн ур чадварт үнэлгээ хийх замаар Нянгийн эсрэг эсэргүүцлийн лабораторийн хүчин чадлыг бэхжүүлж байна.

НҮБ нь Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (НЭМҮТ) зэрэг байгууллагуудтай хамтран тус улсын эрүүл мэндийн тогтолцоонд зайлшгүй шаардлагатай хоол тэжээлийн үйлчилгээг үндэсний хэмжээнд өргөжүүлэн тэлэх зорилгоор “Олон нийтэд түшиглэсэн нярай болон бага насны хүүхдийн хооллолт (ICYF)”, “Хоол тэжээлийн цочмог дутлын цогц менежмент” зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлж үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхыг бэхжүүлж байна. Үүний үр дүнд, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний төвүүдэд Нярай болон бага насны хүүхдийн хооллолтын талаар зөвлөгөө өгөх үйлчилгээний тоо 117-оос 228 болж нэмэгдсэн бөгөөд ийм үйлчилгээнд хоёр хүртэлх насны 15,700 орчим хүүхдийн эцэг, эхчүүд хамрагдсан байна. Түүнчлэн 36,800 хүүхдийг хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэх шинжилгээнд хамруулж, хоол тэжээлийн дутагдалд орсон 580 хүүхдэд зохих эмчилгээг хийж үйлчилсэн байна.

**1,700**  
Нутаг буцаж ирсэн 1,700 иргэн ажил, мэргэжлийн ур чадвар эзэмших хөтөлбөрт хамрагдаад байна.



**4,037**  
Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ)-ээс сэргийлэх, хариу арга хэмжээний тусламж үйлчилгээг эмэгтэйчүүд, өсвөр насныхан болон хөгжлийн бэрхшээлтэй нийтдээ 4,037 иргэнд үзүүлээ.



**Үр дүн 1.6 Илүү эв нэгдэлтэй нийгэмд жендэрийн эрх тэгш байдал, хүний эрх, нэн ялангуяа шилжин суурьшигчдын эрхийг хүндэтгэн хамгаалах, хүртээмжтэй, оролцоог хангасан, олон салбарыг**

**хамарсан, жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг дорвитой хариу арга хэмжээ авах механизмыг бий болгох институц болоод чадавхыг бэхжүүлнэ.**

Монгол Улсын жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтыг ахиулахад НҮБ чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. НҮБ-ын зүгээс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (ГБХТХ) болон Үйл ажиллагааны стандарт журамд үнэлгээ хийх, үр дүнг нь олон нийтэд түгээн танилцуулахад дэмжлэг үзүүлээ. Цаашлаад, Жендэрт суурилсан хүчирхийллийн үндэсний хэмжээний анхны судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулах, мөн түүний гүнзгийрүүлсэн дүн шинжилгээний үр дүнг шийдвэр гаргах өндөр түвшинд танилцуулахад мэргэжлийн тусалцаа үзүүлсэн. Эдгээр хоёр төслийг хэрэгжүүлэхэд НҮБ чухал үүрэг гүйцэтгэсний үр дүнд ач холбогдол өндөртэй бодлогын зөвлөмжүүдийг гаргаж чадлаа. Мөн жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг эрүүл мэндийн салбарын авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээнд үнэлгээ хийж тайлан, зөвлөмжийг холбогдох талуудад хүргүүлсний үр дүнд талууд Эрүүл мэндийн яамтай хамтран эрүүл мэндийн салбарын жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх хариу арга хэмжээг бэхжүүлэх таван жилийн төлөвлөгөө боловсруулсан.

Олон салбарын хамтын дэмжлэг, чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхийн тулд НҮБ-ын зүгээс кейс менежментийн сургалт, нийгмийн ажлын хяналт удирдлага, хохирогчдод үзүүлэх тусламж, хохирогчдын гэмтлийн эмнэлзүйн менежмент, хууль эрх зүйн тусалцаа, хөгжлийн бэрхшээлтэй хохирогчдод үзүүлэх үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргийн асуудлыг шийдвэрлэх зэрэгт чиглэсэн зорилтот сургалтын арга хэмжээнд дэмжлэг үзүүлж ирсэн. Эдгээр сургалтад төрийн албан хаагчид, хууль сахиулах байгууллагууд, эрүүл мэндийн ажилтнууд, нийгмийн ажилтнууд, төрийн бус байгууллагууд болон бусад олон салбарын мэргэжилтнүүд хамрагдлаа.

НҮБ нь жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хүмүүст чанартай үйлчилгээ үзүүлэхийн төлөө тууштай тэмцэж ирсэн бөгөөд одоо ч үйл ажиллагаа явуулж байгаа бүх нэг цэгийн үйлчилгээний төвүүд (НЦҮТ) болон хамгаалах байруудад техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлсээр байна. Үүний нэг жишээ бол сонгогдсон зургаан НЦҮТ/хамгаалах байранд эмэгтэйчүүдийг эдийн засгийн хувьд хараат бус болгох туршилтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн явдал юм. Энэ хөтөлбөрт хамрагдсан 6 эмэгтэй байнгын ажилтай болж, 15 эмэгтэй (үүнээс 4 нь хөгжлийн бэрхшээлтэй) жижиг бизнес эрхэлж, 1700 гаруй эх нутагтаа буцаж ирсэн цагаач иргэд эргээд нийгэмших мэдлэг, ур чадвартай болсноор амьдрал нь сайжирсан билээ. Цаашлаад, нэг цэгийн үйлчилгээний төвүүд болон хамгаалах байрууд нь 4,037 хүн (3,308 хүүхэд, 729 насанд хүрэгсэд) болон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хоёр хүнд зайлшгүй шаардлагатай үйлчилгээг үзүүлсэн байна. Ийм байгууламжууд нь эмзэг бүлгийн хүмүүст туслахад чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг дээрх баримт илэрхийлж байна.

# СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2: НОГООН, ХҮРТЭЭМЖТЭЙ, ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ



Ургац хураах цаг. © НҮБ-ын ХХААБ

Тайлант жилийн хугацаанд стратегийн хоёрдугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд НҮБ-ын системийн 17 байгууллага нь хэрэгжүүлэгч талуудтайгаа хамтран улсын хэмжээнд нийт 67 дэд үр дүнгийн хүрээнд ажиллаж, 22.8 сая ам.долларын санхүүжилт хийсэн.

**Үр дүнгийн зорилт 2: 2027 он гэхэд Монгол Улсын эдийн засаг илүү төрөлжсөн, шинэлэг, бүтээмжтэй, хүртээмжтэй, 'ногоон' болж, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангаж; ялангуяа эмэгтэйчүүд, залуучуудын зохистой амьжиргааг тэтгэх, 21-р зууны эрэлт хэрэгцээтэй ур чадварыг хөгжүүлэх, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжлийг дэмжинэ.**

Монгол Улсын эдийн засаг 2023 онд тогтвортой байж 7.0 хувиар өслөө. НҮБ-аас эдийн засаг тогтворжиж байгаа энэ үед хүртээмжтэй, эрсдэлд тэсвэртэй ажлын байрыг нэмэгдүүлэх, нэн ялангуяа орхигдох магадлал өндөртэй бүлэгт хүртээмжийг нэмэгдүүлэх, уул уурхайн салбараас бусад салбарыг дэмжих чиглэлд бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллаа. Ажлын байрыг нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах мөн хэрэгцээт ур чадварыг олгох чиглэлд чадавч сайжирсан. Тухайлбал, НҮБ ажил олгогч болоод ажил горилгогч нарыг зуучлах, шаардлагатай байгаа ур чадварыг технологийн дэвшлийг ашиглан олгох, ингэхдээ хувийн хэвшилтэй хамтран ажиллаа. Уул уурхайн бус эдийн засгийн салбарууд, тухайлбал хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадварыг

нэмэгдүүлэх, экспортыг дэмжих стратеги сайжирснаас гадна нэмүү өртгийн сүлжээ бэхжлээ. Хариуцлагатай бизнесийн туршлагыг өргөжүүлэх удирдамж гарснаас гадна шинэлэг, тогтвортой санхүүжилтийг дэмжих боломж нэмэгдсэн. Эдийн засгийн өсөлт өндөр байгаа ч эдийн засгийн төрөлжилт тааруу хэвээр хадгалагдсаар байна. Тухайлбал, 2023 оны байдлаар нийт экспортын 91 хувь нь зөвхөн уул уурхайн салбараас хамаарахаас гадна зах зээлийн хувьд ганцхан БНХАУ-руу гаргаж байгаа нь төвлөрөл өндөртэй байгааг харуулж байна.

Цаашлаад, ажилгүйдлийн түвшин 6.7 (2022) хувьд хадгалагдаж, хөдөлмөрийн зах зээлд ур чадвар сул иргэдийн тоо өндөр байгаагаас гадна залуучуудын гадагшлах урсгал их байгаа нь тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна. Монгол Улсын Хоёр дахь удаагийн Үндэсний сайн дурын илтгэлд хот, хөдөөгийн эдийн засаг, нийгмийн ялгаа эрс нэмэгдэж, хөдөө орон нутагт ажлын байрны олдоц хомс байгааг онцолжээ. Тиймээс бүс болон орон нутгийн хөгжлийг дэмжих нь энэхүү ялгааг бууруулах гол хөшүүрэг болохоос гадна жижиг, дунд аж ахуй нэгжүүдийн экспортын өрсөлдөх чадварыг сайжруулах нь эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой нь харагдаж байгаа юм. Түүнчлэн, тогтвортой, ногоон санхүүжилт, цахим хөгжил, холбоо харилцааны дэд бүтцийн тогтолцоог бэхжүүлэх нь хүртээмжтэй, тогтвортой өсөлтөд хүрэхэд нэн чухал байна.





## ХАА-н салбарт инновацыг хөгжүүлж буй Г. Солонгын түүх

Г.Солонго бол эдийн засагч мэргэжилтэй хүн. Гэвч тэрээр зөгийн хор ашиглан чихрийн шижин өвчнийг анагаах боломжтойг олж харан цааш судлах хүсэлдээ хөтлөгдөн эдийн засгийн салбараас микробиологи чиглэл рүү хөрвөсөн юм. Улмаар, зөгийн хороос үе мөчний өвчин намдаах тос зэрэг эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг гарган авдаг “Magic Bee Foods” компанийг үүсгэн байгуулжээ. Анхлан бизнес эрхлэгчид тулгарах саад бэрхшээл олон хэдий ч зориг гарган Европын холбооны санхүүжилтээр НҮБ-ын ХХААБ-ын зохион байгуулсан “Agripreneurship” тэмцээнд оролцож, түүний шинэлэг бүтээгдэхүүн хоёрдугаар байрыг эзэлжээ.

Хөдөө аж ахуйн салбар дахь инновацыг дэмжих, хөгжүүлэх өргөн хүрээний санаачилгын нэг хэсэг болох энэхүү тэмцээнд оролцсоноор Солонго эрчимжүүлсэн сургалтад хамрагдаж, бизнесийн зөвлөгөө авч, үйлдвэрлэлээ хагас автоматжуулах санхүүжилт авсан юм. Үүний үр дүнд түүний бүтээгдэхүүний борлуулалт 16 дахин нэмэгджээ.

Бизнесийн амжилтаас гадна Солонго нийгэмд эерэг нөлөө үзүүлэхийг эрхэмлэдэг нэгэн юм. Тэрээр орон нутгийн ажилсаг эмэгтэйчүүдийг боловсрол харгалзалгүй ажлын байраар хангаж, тэдэнд өрсөлдөхүйц цалин, уян хатан ажлын цаг, олон төрлийн сургалтын боломжийг бүрдүүлдэг аж. Түүний зорилго бол ядуурлыг бууруулж, ажилтнуудынхаа хувийн болон мэргэжлийн хөгжлийг дэмжих юм.

Солонго судалгааны ажлаа хөхний хорт хавдрын эсрэг зөгийн хорны үзүүлэх үр нөлөөг судлахад өргөжүүлэн тэлж байна. Уг өвчнийг анагаах боломжийн үнэтэй эмчилгээг нээх зорилго тавин ажиллаж байгаа нь энэ юм. Түүгээр ч зогсохгүй бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг өргөжүүлж, олон улсын түншлэлийг бий болгох боломжийг эрэлхийлж байна. Солонгын шинэлэг сэтгэлгээ, нийгмийн хариуцлага нь хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулж байна.

# 1,560

Нийт 1,560 залуучууд мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон цахим боловсролын үр чадвар эзэмших сургалтанд хамрагдаад байна.



# 560

Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлдэг 560 төрийн албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлснээр улсын хэмжээнд ажил хайгч 20,000 гаруй иргэд үр шимийг нь хүртээд байна.



# 268

МУХАУТ-ын дэргэдэх “SheTrades Mongolia Hub” төв байгуулагдаж, 268 бизнес эрхлэгч эмэгтэй үр шимийг нь хүртэж эхлээд байна.



**Үр дүн 2.1 Эмэгтэйчүүд, залуучуудын үр чадвар эзэмших, дахин мэргэших боломжийг өргөжүүлж бизнес эрхлэх сургалтыг зохион байгуулан тэдний зохистой хөдөлмөр эрхлэх, ажилд ороход шаардагдах бүтээлч чадварыг дээшлүүлэх, түүнчлэн дотоод, гадаадын шилжих хөдөлгөөнийг илүү үр дүнтэй удирдах зэргээр эмэгтэйчүүд, залуучууд, орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэх институтийн чадавхыг бэхжүүлнэ.**

2023 оны хувьд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бэхжүүлэхэд НҮБ-ын зүгээс чухал үүрэг гүйцэтгэлээ. Тухайлбал, i) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд стратегийн зарим нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэн боловсруулах (шинэчилсэн найруулга хийгдэж байна), ii) Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын (ТМБС) бодлогыг шинэчлэн боловсруулах, iii) Сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны удирдамжийг шинэчлэн боловсруулж, улмаар Боловсролын тухай шинэ хуульд тусгаж батлуулах, iv) Хүнс, хөдөө аж ахуйн салбарын Хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх стратеги, 2023-2028 онд хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах зэрэг олон хууль, бодлогын бичиг баримт боловсруулалтад дэмжлэг үзүүлсэн ажиллаа.

НҮБ нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хувь хүмүүсийн нөхцөл байдал, үр чадвар, мэргэжил мэргэшилд нийцүүлэх зорилгоор төв, орон нутгийн түвшин дэх төрийн хөдөлмөр эрхлэлтийн газрууд “хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (profiling)”-ний аргыг ашиглан “үйлчлүүлэгчид суурилсан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ” үзүүлэх шинэ загварыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Энэхүү дэмжлэгийн үр дүнд хөдөлмөр эрхлэх чадварын

үнэлгээ тогтоох үйлчилгээ үзүүлэх сургалтад төрийн албаны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан 560 гаруй мэргэжилтэн хамрагдаж, 2023 оны эцсийн байдлаар улсын хэмжээнд 20 гаруй мянган ажил хайгчдад энэ төрлийн үйлчилгээг үзүүлжээ. 2022 онтой харьцуулахад үйлчилгээ авагчдын тоо 55 хувиар нэмэгдсэн байна. Түүнчлэн төрийн албаны хөдөлмөр эрхлэлтийн портал (www.ejob.gov.mn) дахь хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ тодорхойлох үйлчилгээг цахимжуулахад НҮБ дэмжлэг үзүүлснээр бичиг цаасны ажлаас ангижрах том алхам болсон юм. Түүнчлэн, шинээр үүсч буй технологи (тухайлбал, Блокчейн, ХОУ/AI болон 5G)-удыг ашиглах засгийн газрын чадавх нэмэгдсэн, цаашлаад ТМБС-н төвийн төгсөгчдийн ажил эрхлэлтийг хянах, зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлтийг таамаглах, түүнд шаардлагатай тоон өгөгдлийг цуглуулах цахим шийдлийг хөгжүүлжээ.

НҮБ болон хувийн хэвшлийн нягт хамтынажиллагааны үр дүнд 10 аймгийн Залуучуудын хөгжлийн төв (ЗХТ)-д түшиглэн дижитал төвүүдийг байгуулан, өргөжүүлж Өвөрхангай аймгийн гурван суманд амьдрах ухааны боловсрол олгох танхимуудыг нээн ажиллуулж байна. Энэ төсөл нь орхигдох эрсдэлтэй залуучуудад 21 дүгээр зуунд шаардагдах үр чадвар олгож хөгжүүлэхэд ихээхэн дэмжлэг үзүүлж байна. НҮБ төрийн бус байгууллагуудтай хамтран орон нутгийн өсвөр үеийн залуучуудад ирээдүйн ажил эрхлэлтэд нь шаардлагатай үр чадварыг (харилцааны, өөрийгөө илэрхийлэх, багаар ажиллах, олон нийтийн өмнө ярих, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх) одооноос эзэмшүүлж бэлтгэх, чанартай сургалт, үйлчилгээ үзүүлэхэд төрийн байгууллагуудын чадавхыг нэмэгдүүллээ. Энэхүү ажлын үр өгөөжийг 440 орчим өсвөр насны хүүхэд (274 охид) хүртсэн юм. Түүнчлэн, хөдөө орон нутгийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, залуучуудад зориулсан ногоон ажлын байр бий болгох, умаар тэдний үр чадварыг хөгжүүлэх зорилгоор үр чадварын хэрэгцээний үнэлгээ хийж, хөрөнгө нөөц дайчлах ажлыг зохион байгуулсан.

НҮБ нь бүс нутгийн хөгжил, хотоос хөдөө рүү чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөнийг дэмжих зорилгоор Хот, хөдөөгийн сэргээн босголт, газар зохион байгуулалт, хот төлөвлөлт зэрэг асуудал хариуцсан үндэсний комиссыг байгуулахад дэмжлэг үзүүлж, дотоодын шилжих хөдөлгөөнд оролцогчдын эрхийг хамгаалах бодлогын болоод институцийн чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсан. Түүнчлэн шилжилт хөдөлгөөний бодлого боловсруулахад шаардагдах үндэсний статистикийн чадавхыг бэхжүүлэн ажиллаа. Мөн залуучуудын сайн сайхан байдал, бүтээмжийг дэмжих институцийн болоод

дэд бүтцийн чадавхыг бэхжүүлэхэд НҮБ-ын зүгээс техникийн туслалцаа үзүүлж байна.

# 6,900

Мах, сүү, сүүн бүтээгдэхүүний уур амьсгал, байгаль орчинд ээлтэй өртөгийн сүлжээнээс 6,900 малчин үр шим хүртээд байна.



# 10

аж ахуйн нэгж хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, халал буюу зөвшөөрөгдсөн, органик бүтээгдэхүүн, арьс ширний үйлдвэрлэл дэх байгаль орчны стандартыг хангаж байгаа эсэхтээ аудит хийлгэн, олон улсын баталгаажуулалтын гэрчилгээг аваад байна.



**Үр дүн 2.2 Эдийн засгийг төрөлжүүлж, нөөцийг үр ашигтай зарцуулах арга хандлагад шилжих, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжил, дижитал хувьсалыг дэмжих, улмаар өрсөлдөх чадвартай, технологийн хувьд эрс шинэлэг, бүтээмжтэй эдийн засгийг хөгжүүлэх, жижиг аж ахуйн нэгжүүд илүү ногоон үйл ажиллагаа эрхлэх, олон улсын нэмүү өртгийн сүлжээнд холбогдох, албан ёсны эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, нөөцийг үр ашигтай, тогтвортой ашиглах зэрэг нөхцөлийг хангасан бодлого, стратеги, институцууд бий болсон байна.**

Бодлогын түвшинд, НҮБ дараах бичиг баримтуудад дэмжлэг үзүүлэн ажиллаа. Үүнд, i) Монгол Улсын экспортын стратеги (ҮЭС/NES) - өрсөлдөх чадвар, төрөлжилтийг нэмэгдүүлэхэд баримтлах уул уурхайн бус тэргүүлэх салбарын худалдааны стратеги боловсруулах, ii) Ногоон, өрсөлдөх чадвартай, экспортод чиглэсэн тогтвортой хөгжлийн дунд хугацааны салбарын стратеги (2023-2028) боловсруулах, iii) Төв, орон нутгийн түвшинд хэлэлцүүлэг (800 гаруй төлөөлөгчдийг оролцуулан) зохион байгуулах замаар Үндэсний дасан зохицох төлөвлөгөө боловсруулах, iv) Цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээ, цахим худалдаа эрхлэх, оролцоход тулгарч буй саад бэрхшээл, хүндрэлийг даван туулах арга замыг тодорхойлж, зөвлөмж боловсруулах, v) Эдийн засаг, нийгмийг тогтвортой хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр 2024-2030 онд хэрэгжүүлэх 17 сум орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах зэрэг багтана.

Хуурай боомтыг хөгжүүлэх засгийн газрын чадавхыг бэхжүүлэх зорилгоор долоон хуурай боомтод үнэлгээ хийж, сургалт семинар, танилцах аялал зохион



Нийт 195 бичил уурхай  
эрхлэгчдийн үйл ажиллагаанд  
нь дэмжлэг үзүүлэв.

байгуулахад НҮБ-ын зүгээс дэмжлэг үзүүлсэн нь анхны олон улсын чанартай Замын-Үүд хуурай боомт байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын чухал шийдвэр гарахад хувь нэмэр оруулсан. НҮБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Засгийн газар Эрчим хүчний төлөвлөлтийн үндэсний шинжээчийн ТХЗ-ын арга зүйг боловсруулах ажилд оролцсон ба энэ нь ТХЗ 7-д хүрэхэд бодлогыг илүү судалгаа, мэдээлэл суурилсан байх боломжийг нэмэгдүүлсэн юм. Түүгээр ч зогсохгүй тээврийн бодлого, стратеги боловсруулахад тээврийн ухаалаг технологи (цаасгүй тээвэр) болон их өгөгдлийг ашиглах чиглэлд төрийн байгууллагын чадавхыг бүрдүүлэхэд дэмжин ажиллалаа.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг тооцсон, байгаль орчиндээлтэй махболон сүүн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлснээр нийт 6,900 малчин үр өгөөжийг нь хүртлээ. НҮБ-ын дэмжлэгтэй төслүүдийг хэрэгжүүлснээр малын нийт ашиг шим нэмэгдэж, хувийн хэвшлийн компаниудын оролцоо мал сүргийн нийлүүлэлтийн тогтолцоо, чанарын үзүүлэлтэд эерэгээр нөлөөлж, мал эмнэлгийн хяналт сайжирч, бэхжиж байна. Түүнчлэн малчдын орлого ч тогтвортой болж байна. НҮБ-ын төсөл хөтөлбөрийн үр дүнд орон нутгийн нөөцийн тэжээлийн нийлүүлэлт сайжирч, зүүн бүсийн нийт малчид үр өгөөжийг нь хүртэж байна.

Мал сүрэг, малын ялгадас хаягдлаас дамжих бруцеллёзын халдвар, сүүний нянгийн эсрэг бодис, гар хөл амны өвчин, шүлхий, хивэгч малын хортон шавьж зэргээс сэргийлэх вакцинжуулалтын шинэ тактикийг мөрдөх, малыг эрүүл эсэхийг баталгаажуулах механизмыг хөгжүүлэх чиглэлээр НҮБ-ын дэмжлэгтэй төсөл хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд БНХАУ руу экспортлох махны хэмжээ нэмэгдэж, 2023 онд махны экспорт түүхэн дээд амжилт тогтоосон бөгөөд Вьетнам улс руу ч мөн шинэ зах зээл нээгдсэн. НҮБ-ын дэмжлэгтэйгээр төсөл хэрэгжүүлсний үр дүнд 10 аж ахуйн нэгж аудитын шалгалтад тэнцэж, Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, Халал, Органик, Арьс ширний ажлын хэсгийн (LWG) байгаль орчны стандарт зэргийн шаардлагыг хангаж олон улсын гэрчилгээ авч, экспортын өрсөлдөх чадвараа дээшлүүлсэн төдийгүй 2024 оноос орлого нь хоёр дахин нэмэгдэх төлөвтэй байна. Түүнчлэн Өмнөговь аймгийн тэмээний сүү нийлүүлэх сүлжээний шилдэг туршлагыг Баянхонгор, Говь Алтай аймагт нэвтрүүлсэн. Ингэснээр тэмээний сүүн бүтээгдэхүүний экспорт гурав дахин, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 10 дахин нэмэгдсэн байна.

**Үр дүн 2.3 Ил тод, урьдчилан тооцоолох боломжтой хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэх, үр ашигтай, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжилд чиглэсэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих эрс шинэлэг санхүүжилтийн тогтолцоог бий болгох Засгийн газрын чадавх бэхжиж, бизнесийн хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжих, хүний эрхийг дээдлэх, нийгэм, байгаль орчин, өмч хөрөнгөд ээлтэй бодлогууд хэрэгжинэ.**

НҮБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, арилгах Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө 2023-2027 онд хэрэгжинэ. Энэхүү төлөвлөгөө нь Монгол Улсын Засгийн газар, НҮБ, бизнес эрхлэгчид, иргэний нийгэм болон бусад оролцогч талуудын хариуцлагатай бизнесийн дадал туршлагыг дэмжих хамтын хүчин чармайлтын илэрхийлэл юм. Бизнес ба хүний эрх төслийн хүрээнд Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд төрийн албаны 475 ажилтаныг сургалтад хамруулж чадавхыг нь сайжруулсан. Мөн Монголын Хүний эрхийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын форумын манлайлал дор 50 орчим иргэний нийгмийн байгууллагууд хамтран төрийн бодлого, үйл ажиллагаа хоорондын ялгааг арилгах зорилгоор Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх нэг сарын аян өрнүүлсэн.

Ногоон санхүүжилтийг эрчимжүүлэх зорилгоор НҮБ-ын дэмжлэгтэйгээр Монголбанк, Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо хамтран Монгол Улсын ногоон санхүүжилтийн суурь үнэлгээг хийж, эхлэлийн тайланг бэлтгэн танилцуулсан. Мөн Монгол Улсын газар зүйн заалт (ГЗЗ/ГІ)-ын хууль эрх зүйн орчинд үнэлгээ хийж, ГЗЗ-ын гэрчилгээтэй бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд нэвтрүүлэхэд учирч болзошгүй хууль эрх зүйн асуудал байгаа эсэхийг тодорхойлсон. НҮБ нь Монгол Улсын Засгийн газартай хамтран мөнгөн ус ашигладаггүй боловсруулах технологи нэвтрүүлэх, нийтийн аж ахуйн нэгжийн бизнес загварыг хөгжүүлэх, хадгаламж, зээлийн хоршоо байгуулах зэрэг чиглэлээр нийт 195 уурхайчдад дэмжлэг үзүүлсэн.

Түүнчлэн, уурхайчдын бүртгэлжүүлэх, хуулиас гадуурх үйл ажиллагааг зогсоох тал дээр холбогдох байгуулалтуудад дэмжлэг үзүүлэн ажиллаа.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Засгийн газар санхүүгийн шинэлэг арга, хэрэгсэл, тухайлбал ТХЗ-н бонд, жендерийн бонд, Хүрээлэн буй орчин, нийгэм, засаглал тайлагнах стандарт зэргийг хөгжүүлснээс гадна ногоон бөгөөд ТХЗ-уудтай уялдсан санхүүжилтийг нэмэгдүүлэх арга, аргачлалыг боловсрууллаа. Мөн айл өрхүүдэд хөнгөлөлттэй

ногоон зээл олгох зорилгоор Банк бус санхүүгийн байгууллагатай хамтран тусгай зориулалтын CHIP багц төслийн зээлийн Эргэлтийн санг байгуулан ажиллуулж байна. НҮБ-ын туслалцаатайгаар Хөдөө аж ахуйн сайн туршлага (GAP)-ыг нэвтрүүлж чадсан нь хүнсний ногоо, газар тариалангийн салбарт төрөөс татаас хуваарилах үндсэн шалгуур болсон ба 70 газар тариалан эрхлэгч тус шалгуурын хүрээнд хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагаас гэрчилгээгээ аваад байна.

## Турк улсаас эргэн ирж бүхнийг шинээр эхэлсэн Мягмаржавын гэр бүлийн түүх



Өндөр цалинтай ажил, илүү сайн боломж эрэлхийлж хилийн дээс алхсан залуучуудын нэг нь Мягмаржавын гэр бүл юм. Тэрээр эхнэр Оюунбилэг болон хоёр хүүхдийн хамт 2018 онд Турк улсыг зорьжээ. Тэнд очоод оёдолд суралцаж, ажил төрөлтэй болоод үр хүүхдүүдийнхээ боловсрол, ирээдүйн сайн сайхны төлөө шургуу ажиллаж байв. Тэд Туркэд урт хугацаагаар орших суух төлөвлөгөөтэй байсан ч визний асуудлаас үүдэн Турк улсад хорионд орсон юм. Хүний газар хүнд байдалд орсон Мягмаржавын гэр бүл НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагад (ОУШХБ) хандсанаар хоёр хүүхдийнхээ хамт Монголдоо аюулгүй эргэн иржээ.

ОУШХБ-ын тусламж эх орондоо эргэн ирсний дараа ч үргэлжилсэн юм. ОУШХБ-аар дамжуулан тэтгэлэгт хамрагдсанаар оёдлын машин, багаж хэрэгсэл, материалууд авч төрөлх Эрдэнэт хотдоо оёдлын цех нээжээ. Бие даан бизнес эрхлэхэд бишгүй сорилтууд тулгарсан ч оёх ур чадвартаа итгэлтэй байсны хүчинд

үйлчлүүлэгчдийнхээ хүрээг тэлж, бизнес нь тогтвортой өсөж байгаад баяртай байна.

2023 онд ОУШХБ тэдний гэр бүл болон тэдэнтэй адил нөхцөл байдалд орсон бусад хүмүүст ч тусламжийн гараа үргэлжлүүлэн сунгасан нь эх орондоо эргэн ирэгсдэд зориулсан эрүүл мэндийн үзлэг, сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөө бизнес коучинг чиглэлээрх цуврал арга хэмжээнүүд байсан юм. Оюунбилэгийг шинэ төрсөн хүүхдээ асрахын хажуугаар бизнесээ явуулахад нь сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ маш их дэмжлэг болсон ажээ.

Одоогоор тэдний гэр бүл оёдлын бизнесээ өргөжүүлэхээр хичээнгүйлэн ажиллаж байгаа бөгөөд зорилгодоо хүрэхээр зүтгэж байна. Мягмаржав ирээдүйгээ өөдрөгөөр харж байгаа бөгөөд амьжиргаагаа баталгаажуулахад нь эргэн суурьшигчдад туслах хөтөлбөр чухал үүрэг гүйцэтгэсэн гэдгийг онцоллоо.



**Үр дүнгийн зорилт 3: 2027 он гэхэд Монголын нийт иргэд, экосистем нь нотолгоонд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй байгалийн нөөц, байгаль орчны тогтвортой менежмент, гамшгийн эрсдэлийг бууруулах чадавх сайжирснаар уур амьсгалын өөрчлөлтөд илүү тэсвэртэй болсон байна.**

НҮБ-аас гамшгийн үеийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах, цаг агаарын хүнд нөхцөлд бэлтгэлтэй байхад институцын тогтолцоог сайжруулж, эрсдэлд тэсвэртэй тоног төхөөрөмжөөр хангахаас гадна гамшгийг урьдчилан тооцоолох аргачлалыг нэвтүүлэх зэргээр хүчин чармайлт гаргаж ажиллаа. Энэхүү дэмжлэг нь судалгаанд суурилсан төлөвлөгөө боловсруулах, эрсдэлийг урьдчилан таамаглаж, эртнээс бэлтгэх боломжийг төрийн шийдвэр гаргах түвшинд төдийгүй орон нутгийн холбогдох нэгжүүдэд олгосон юм. Энэхүү дэмжлэг нь сүүлийн жилүүдэд Монгол Улсад давтамж нь нэмэгдээд буй зудын аюул, түймэр, үер усны эрсдэл зэрэгт нэн шаардлагатай дэмжлэг юм. 2023 тухайд Монгол Улс зудтай, 179 байршил түймэр гарсан, Улаанбаатар хотод хоёр удаагийн үер, усны аюул нүүрлэсэн жил байлаа. Түүнчлэн, орон нутагт хуурай газар болон гол, нуурын усыг хамгаалах ажил хийгдэж, байгалийн нөөцийг удирдах арга дадлыг хэвшүүллээ. Мөн малчин

иргэдийн орлогын төрлийг нэмэгдүүлэх, тэдгээрийн чадавхыг дээшлүүлэхэд чармайлт гарган ажилласан. Монгол Улсын Үндэсний сайндурьн хоёрдахь удаагийн илтгэлд хуурай газрын экосистемийг хамгаалахад тодорхой ахиц дэвшил гарч байгааг тэмдэглэсэн. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийн экологийн тэнцвэрт байдлыг хамгаалж, сайжруулах зорилготой “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн Монгол Улсад амжилттай хэрэгжиж байна. Мөн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ ч нэмэгдсэн. Монгол Улс нь Кунмин-Монреалийн дэлхийн биологийн олон янз байдлын тогтолцооны дагуу 2030 он гэхэд улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нийт нутаг дэвсгэрийнхээ 30 хувьд хүргэх зорилт тавьж, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх үүрэг хүлээсэн.

Хэдийгээр ололттой тал байгаа ч саад бэрхшээл байсаар байна. Тухайлбал, орон нутагт эрсдэлд тэсвэртэй байх чадавхыг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, өвс тэжээлийн нөөцийг оновчтойгоор нэмэгдүүлэх шаардлагатай байна. Цаашлаад, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, удирдах болоод эдийн засгийн үр өгөөж болон байгалийн баялагийн нөөц ашиглалтыг оновчтой

хослуулах зэрэгт олон нийтийн ойлголт, мэдлэгийг сайжруулах шаардлагатай байна. Монгол Улс нь хөгжлийн хурдасгуур болгон зарласан 12 чиглэлийн нэг нь байгаль орчны тогтвортой байдлыг хадгалах, аливаа гамшиг, эрсдэлд тэсвэртэй байх замаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, сөрөг нөлөөг бууруулах юм. Түүнчлэн, Монгол Улс нь НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн Талуудын 17 дугаар бага хурал (COP-17)-ыг 2026 онд эх орондоо зохион байгуулна. Энэ нь газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэхэд том түлхэц болно.

**92,582**

Улаанбаатар хотын 92,582 оршин суугч үерийн хамгаалалтын далан, үер усны эрсдэлийг даван туулах ариун цэврийн байгууламжтай болж, эрсдэлийн удирдлагад суралцаад байна.



**1,196**

Гэр хорооллын 1,196 өрх нүүрсээр галладаг зуух, яндангаа сольж, Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн (ЧИП) багц"-ыг хэрэглээнд нэвтрүүлээд байна.



**Үр дүн 3.1. Дасан зохицох чадавхыг сайжруулж, нийгэм, эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, гамшгийн улмаас нүүлгэн шилжүүлэх эрсдэлийг сааруулахын тулд уур амьсгалын өөрчлөлтөд мэдрэмжтэй хариу арга хэмжээ авах төлөвлөлт, хөгжлийн эрх зүйн зохицуулалтын тогтолцоо бэхжсэн байна.**

Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн хүрээ баримт бичгийн дунд хугацааны тайланг боловсруулахад Монгол Улсын Засгийн газарт, 2018-2020 онд хэрэгжүүлэх гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахад орон нутгийн засаг захиргааны нэгжүүдэд НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн. Түүнчлэн найман голын сав газрын захиргаад дунд болон урт хугацааны дасан зохицох арга хэмжээний менежментийн төлөвлөгөө боловсруулахад НҮБ дэмжлэг үзүүллээ.


“Орчны эрүүл мэндийн асуудлаарх олон улсын болон үндэсний чуулгууд”, “Цэнхэр алт”, “Ариун цэврийн өрөө-2023”, “Эрүүл мэндийн төлөө шийдэл” санаачилга зэрэг үндэсний хэмжээний кампанит ажлууд зохион байгуулах замаар эрүүл, тогтвортой нийгмийг сурталчлан таниулах төсөл хөтөлбөрүүдийг НҮБ дэмжиж ирсэн. Мөн аюулт үзэгдлүүдтэй тэмцэж хариу



арга хэмжээ авах салбаруудын чадавхыг бэхжүүлэх, Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, байгаль орчинд ээлтэй эрүүл мэндийн байгууламжийн талаарх ДЭМБ-ын удирдамжийг (CRESHCF) батлах засгийн газрын чадавхыг сайжруулах зэрэг чиглэлээр өнгөрсөн онд НҮБ-аас дэмжлэг үзүүлэн ажиллаа. Цаашлаад, эрсдэлийн удирдлагын цогц систем (CRM) болон Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлын үнэлгээний хяналтын хуудас (CRS) зэргийг нэвтрүүлэх замаар Онцгой байдлын ерөнхий газрын (ОБЕГ) чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

2023 онд НҮБ-ын дэмжлэгтэйгээр ОБЕГ-ын 150 ажилтаныг сургалтад хамруулж, чадавх сайжруулсан бөгөөд онцгой байдлын үед хариу арга хэмжээ авахад зориулж шаардлагатай техник хэрэгслээр хангасан. Түүнчлэн үерийн хамгаалалтын дэд бүтцийг барих, ариун цэврийн байгууламжийг үерт тэсвэртэй болгож сайжруулах, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа явуулах төслүүдийг хэрэгжүүлсний үр өгөөжийг Улаанбаатар хотын гэр хорооллын захын 10 хорооны 92,582 оршин суугчид (50.03 хувь нь эмэгтэй) хүртсэн. Үерийн аюулаас хамгаалах нийт 4,517 км урттай таван дэд бүтцийг барьж, Улаанбаатар хотын хойд хэсгийн гэр хорооллын 221 га талбайг (2,629 өрхийн 27,201 хүн) үерийн аюулаас хамгаалсан. Түүнчлэн хүүхдүүдийг агаарын бохирдлоос хамгаалах зорилгоор халаалт, дулаалга, агаар сэлгэлтийн бараа бүтээгдэхүүний ЧИП/CHIP багц төсөл хэрэгжүүлсэн бөгөөд үүнд нийт 3,824 иргэд тэдгээрийн 1,530 нь хүүхэд, мөн долоон (7) гэр цэцэрлэг (289 хүүхэдтэй) үр шимийг нь хүртлээ.

Хавтгай тэмээ хамгаалах дэлхийн холбоо байгуулагдаж, Монголд "Хавтгай тэмээ хамгаалах дэлхийн өдөр"-ийг анх удаа тэмдэглэв.



49,000

Доройтолд орсон бэлчээр, ойн чөлөө, гол мөрний дагуух ой бүхий нийт 49,000 га талбайг нөхөн сэргээгээд байна.



**Үр дүн 3.2 Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг тооцсон, газар, ой, биологийн олон янз байдал, ус зэрэг байгалийн нөөцийн тогтвортой менежмент, мал аж ахуйн бүтээгдэхүүний өртгийн сүлжээг сайжруулах, онцгой байдлын үед авах арга хэмжээг үр дүнтэй төлөвлөж зохицуулах зэргээр байгалийн нөөцөөс ихээхэн хамааралтай малчдын нөхөрлөлүүдийн эрсдэлийг даах чадварыг бэхжүүлнэ.**

НҮБ-ын дэмжлэгтэйгээр уур амьсгалын өөрчлөлтийн



## Дархадын цэнхэр хотгорын дархан байгаль хамгаалагч

Тэрбээр дөрвөн цагийн эргэлтэд уул хад, хээр тал, ой хөвч тайгаар гэр хийж, ан амьтнаар хань хийж явахдаа амь дүйсэн эрсдэлүүдтэй тулгардаг ч эх дэлхийн экосистем, биологийн олон янз байдал, эх орныхоо байгаль орчныг хамгаалахын төлөө ажиллаж буй Монгол Улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээнд болон орон нутгийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын харьяанд ажиллаж буй 1000 гаруй байгаль хамгаалагчдын нэг.

Магсарөөрийн хариуцан хамгаалдаг Шарга-Хавхын голын ай сав газрын 86 мянган га газар нутгийг гарын арван хуруу шигээ мэднэ. Байгаль хамгаалагч хүн угаасаа ийм л байх ёстой. Хойч үедээ энэ сайхан эх орноо бүрэн бүтэн өвлүүлэн үлдээхэд хувь нэмрээ оруулж буй энэ ажлаараа үргэлж бахархаж явдагаа тэрээр хэлж байв.

Тайгын 1 га нь талын 10 га-тай тэнцэхээр бэрх бартаа саадтай байдаг аж. Байгаль хамгаалагчид ийм хүнд нөхцөлд хамгааллын ажил үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ байгаль дэлхий, хүрээлэн буй орчин, экосистем хэрхэн яаж хувьсан өөрчлөгдөж байгааг газар дээр нь байнга харж ажиглаж суудаг судлаачид гэж хэлж болно.

"Манай нутагт 3-4 сар гэхэд мал ногоо иддэг байсан бол одоо цаснаасаа салахгүй болсон. Өвөл цас их унаж, улам хүйтэрч хатуу ширүүн болж байна. Байгаль цаг агаарын гамшигт үзэгдэл ихсээд ойр ойрхон давтагдаж, нэг тийм хачин болсон шүү. Шаргын голын гүүрнээс урагших хэсэг тэр чигээрээ элс болох гээд байна" гэж тэрээр сэтгэл зовнин ярьж байлаа.

ХБНГУ-ын санхүүжилтээр НҮБХХ-өөс хэрэгжүүлж буй Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга төслөөс БОАЖЯ, Сангийн яамны дэмжлэгтэйгээр Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулахад орон даяаранхаарчажиллаж байгаад Магсар болон бусад байгаль хамгаалагчид талархаж байна. Тус сум нь төсөвт төвлөрсөн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалд ч багагүй хөрөнгийг шийдвэрлэсэн сайн туршлагатай аж.

Байгаль хамгаалагч Ш. Магсар © UNDP Mongolia

улирлын болон урт хугацааны урьдчилсан мэдээг боловсруулах засгийн газрын чадавх сайжирсан. Их хэмжээний цас орсны улмаас өвс тэжээлийн нөөц хомсдох, зам хаагдах, малчин өрхийн амьжиргаанд хүндрэл учрах зэрэг байгалийн үзэгдлүүдийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг илэрхийлэх Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн индекс (CRI) тооцох аргачлал болон Уур амьсгалын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээллийн газрын зураглалыг боловсруулж бэлэн болгосон. Эдгээр урьдчилсан мэдээллийн зураглалд үндэслэн орон нутгийн удирдлагууд өвөлжилтийн бэлтгэлээ сайтар хангаж, хүнд нөхцөл үүсэхэд эрт хариу арга хэмжээ авч эхлэх боломжтой бөгөөд 2023 онд 37 сум орон нутгийн газар төлөвлөлтөд тус мэдээллийг ашигласан.

Бэлчээрийн тогтвортой менежмент, биологийн олон янз байдлыг хамгаалах бэлчээрийн нэгдсэн менежментийн тухай журмыг НҮБ-ын дэмжлэгтэйгээр боловсруулж, Улсын Их хурлаар хэлэлцүүлэхээр өргөн бариад байна. Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлыг хамгаалахад чиглэсэн байгаль орчинд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй мал аж ахуйг хөгжүүлэх стратегийн бодлого, Газрын нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулахад мөн НҮБ дэмжлэг үзүүлсэн.

Нөөцийн менежментийг сайжруулах зорилгоор НҮБ-ын дэмжлэгтэйгээр уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй газар, усны менежментийн туршлагыг нэвтрүүлсэн. Үүний үр дүнд 49 мянган га талбайн эвдэрч доройтсон бэлчээр, ой мод, гол горхины эрэг орчмын мод буцыг нөхөн сэргээж, урт хугацаанд орон нутгийн иргэд арчлан хамгаалж, тогтвортой байдлыг нь хангаж байна.

Иргэдийн оролцоотой орон нутгийн бэлчээрийн менежментийн зохицуулалтын үр дүнд 82 мянган га талбайн бэлчээрийн менежментийг сайжруулсан. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд НҮБ дэмжлэг туслалцаа үзүүлж байна. Тухайлбал, хуурай цөлийн бүсийн 75 га бут сөөг, шилмүүст ой бүхий 447 мянган га талбайг ойн тогтвортой менежментийн төлөвлөгөө, арга ажиллагаанд хамруулж 11,5 га шилмүүст ойг байгалийн нөхөн сэргээлтэд зориулан хашаалсан. Түүнчлэн 282 га талбайд хадлан тариалан, бэлчээрийн менежментийн арга хэмжээг авч онцгой байдлын үед ашиглах тэжээлийн нөөцийн 22 агуулах шинээр барьж, засварлахад НҮБ дэмжлэг үзүүллээ.

**28,371**  
Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтаас нийт 28,371 иргэн үр шим хүртэж байна.



49 км<sup>2</sup>

Хуурай газар болон далай тэнгисийн усан орчин бүхий нийт 49 х.д. км талбайг хамгаалалтанд авч, ашиглалт хамгаалалтын зохистой менежментийг нэвтрүүлж эхлээд байна.



**Үр дүн 3.3 Байгалийн нөөцийн тогтвортой менежмент, биологийн олон янз байдлын алдагдлыг бууруулж экосистемийн үйлчилгээг сайжруулах талаар мэргэжлийн мэдлэг чадвартай институтууд, аж ахуйн нэгжүүд, хүн амын бүлгүүд төлөвшсөн, генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас гарах ашиг, үр шимийг тэгш, шударгаар хуваалцах, ялангуяа малчдад хүртээмжтэй байх нөхцөл бүрдсэн, чадавх бэхжсэн байна.**

НҮБ-ын дэмжлэгтэйгээр малчин эмэгтэйчүүдийн бүлэг өдөрт 1,000 литр сүү боловсруулах хүчин чадал бүхий сүү боловсруулах цехийг байгуулсан. НҮБ-ын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан сүүний сургалтад малчин эмэгтэйчүүд хамрагдан чадавхжсанаар орон нутгийн сүү, сүүн бүтээгдэхүүний нэр төрөл олширч, зөгийн балтай сүү, тараг, цөцгий, ванилийн ааруул, исгэлэн ундаа зэрэг таван нэр төрлийн бүтээгдэхүүн зах зээлд шинээр гарсан. Шинээр боловсруулсан эдгээр бүтээгдэхүүнийг 2022 оноос эхлэн ерөнхий боловсролын сургуулиудын 1-5 дугаар ангийн 406 сурагчдын хэрэгцээнд долоо хоногт 1-3 удаа тогтмол нийлүүлж байна.

Монголын Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо нь 2023 онд үндэсний тариалан эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор НҮБ-ын дэмжлэгтэйгээр сүлжээ байгуулж залуучууд, тариалан эрхлэгч эмэгтэйчүүдийг идэвхтэй хамруулж өөр хоорондоо холбогдох боломжийг бүрдүүлсэн. Сумдын түвшинд мал аж ахуйн загвар нэгж байгуулах замаар залуучуудын ур чадварыг хөгжүүлэх институтийн чадавхыг бэхжүүлэхэд НҮБ үнэтэй хувь нэмэр оруулсан. "Хөдөө аж ахуй, газар тариалан эрхлэгчдийг дэмжих хөрөнгө оруулалт" туршилтын төсөл хэрэгжүүлсний үр дүнд 160 (хөдөө орон нутгийн 90, Улаанбаатарын 70) гарааны бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүллээ. Мөн газар тариалан эрхлэгчдийн 10 орчим байгууллага/хоршоодод үзүүлсэн дэмжлэгийн үр өгөөжийг 1970 гишүүн шууд хүртсэн байна.

НҮБ Монголын Үндэсний Комисстой хамтран Хөвсгөл нуурын бүс нутагт тогтвортой эко аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор орон нутаг дахь аялал жуулчлалын операторууд, малчдын (100 хүн хамрагдсан тэдний 40 нь эмэгтэй) чадавхыг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлсэн. Түүнчлэн олон нийтэд түшиглэсэн эко аялал жуулчлалын бизнесийн загваруудыг турших төслийг хэрэгжүүлж цаашид тэдгээрийг малчдын бүлгүүд болон орон нутгийн засаг захиргаад үргэлжлүүлэн хөгжүүлэх боломжийг бүрдүүллээ.



"Тогтвортой хөгжлийн төлөө үйлдлээрээ нэгдье!" нөлөөллийн аян нь олон нийтийг ТХЗ-ын төлөө эвлэлдэн нэгдэж, өөрчлөлтөд манлайлахыг уриалсан юм. © НҮБ-ын СЗГ

## СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3: ХҮН ТӨВТЭЙ ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙТ ЁС, ХҮНИЙ ЭРХ

2023 онд стратегийн гуравдугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд НҮБ-ын системийн 14 байгууллага хамтын хүчин чармайлт гаргасны үр дүнд улсын хэмжээнд хэрэгжүүлэгч түнш байгууллагуудтайгаа хамтран 40 дэд үр дүнгийн хүрээнд ажиллаж 7.0 сая ам.долларын санхүүжилт олголоо.

**Үр дүнгийн зорилт 4: 2027 он гэхэд Монгол Улсын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц нь жендерийн мэдрэмжтэй, оролцоог хангасан, харилцан уялдаатай, нотолгоонд суурилсан, ТХЗ-той уялдсан байж; бүх шатны засаглалын байгууллагууд нь ил тод, хариуцлагатай ажиллаж, хүний эрхийг бүрэн дүүрэн хангаж хамгаалсан, тэгш шударга, эрх зүйт ёсыг хүн бүр, ялангуяа орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд ялгаваргүй эдлэх боломж нөхцөл бүрдсэн байна.**

Монгол Улсын Засгийн газар нь НҮБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсын ТХЗ-ын хэрэгжилтийн явцын талаар хоёр дахь удаагийн Үндэсний сайн дурын илтгэлийг 2023 онд боловсруулсан. Тус илтгэлд "Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоонд томоохон ахиц дэвшил гарсан"-ыг тэмдэглэсэн билээ. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ 2023 оны 5-р сарын 31-ний өдөр баталсан

бөгөөд уг өөрчлөлтөөр УИХ-ын гишүүдийн тоог 76 байсныг 126 болгон нэмэгдүүлсэн.

Түүнчлэн 2023 онд УИХ-ын Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хуулийг баталсан. УИХ-ын Сонгуулийн тухай шинэ хуулиар төлөөлөл, ил тод байдал, шударга ёсны талаарх олон жилийн турш яригдаж ирсэн асуудлыг нягтлан хэлэлцэж 2024 оны сонгуульд жендерийн 30 хувийн квотыг мөрдөхийг зүйлчилж өгсөн. Эдгээр эрх зүйн актыг батлан гаргаснаар хүний эрхийн чиглэлд эерэг өөрчлөлт гарч Хүний эрхийн үндэсний комиссын бүрэн эрхийг тодотгон тодорхойлж, үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг бий болгосны зэрэгцээ Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсан.

Гэсэн хэдий ч төрийн албаныхны авлига газар авч буй арван улсын нэгд Монгол Улс багтсан байна. Төрийн захиргаа удирдлагын салбарт нэгдмэл, цогц уялдаатай, үр дүнд чиглэсэн бодлого боловсруулах чадавх сул байна. Өндөр албан тушаалтнууд, бизнесмэнүүдтэй холбоотой хээл хахууль, хөрөнгө мөнгө шамшигдуулсан, татвараас зайлсхийсэн гэх асуудал нь иргэдийн дургүйцлийг ихээр хүргэж, тэгш бус байдлыг нэмэгдүүлж, боломжийг хязгаарлахын зэрэгцээ байгаль орчны доройтолд нөлөөлж байна.



Санхүүжилт  
(сая ам.доллар)

**Үр дүн 4.1 Хөдөлмөрийн эрх зэрэг хүн амын эмзэг хэсгийн эрхийг хамгаалах, дэмжих, хяналт тавих эрх үүрэг бүхий шүүх засаглалын байгууллагууд, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс (ХЭҮК), иргэний нийгмийн байгууллагуудын чадавх сайжирна.**

Хүний эрхийг хамгаалагч комиссар болон шинээр байгуулагдсан Дэмжих хорооны чадавхыг бэхжүүлэх зорилгоор НҮБ-аас 2023 онд ХЭҮК-т техникийн туслалцаа үзүүлж Хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулахад хувь нэмэр оруулсны зэрэгцээ хүний эрхийн зөрчлийн талаарх хүйсийн ангилалтай мэдээлэл бүхий Мэдээллийн нэгдсэн сан байгуулахыг дэмжиж ажиллалаа. Монгол Улсад 2022 онд ирж ажилласан НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг болон 2023 онд тус улсад ажилласан Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгчээс ирүүлсэн зөвлөмжийн дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг сайжруулах, цагдан хоригдож буй хүмүүсийн хүний эрхийг хамгаалах чиглэлээр НҮБ ХҮЭК-той идэвхтэй хамтран ажиллаж байна.

Хөдөлмөрийн тухай хууль 2021 онд батлагдаж, 2022 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан 2023 онд Аж үйлдвэрлэл болон хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай ОУХБ-ын 81 болон 129 дугаар конвенцийг УИХ-аар соёрхон батлуулахад НҮБ техникийн туслалцаа үзүүллээ. Хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг тусгасан хөдөлмөрийн байцаагчийн хяналтын хуудас, аж ахуйн нэгж, аймаг, дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн маргаан хянан шийдвэрлэх журам, хөдөлмөрийн маргаан зуучлагчийн ёс зүйн дүрэм зэргийг боловсруулж, 130 хөдөлмөрийн байцаагч, 60 ахлах байцаагчийг сургалтад хамруулан чадавхжуулсан. Албадан хөдөлмөрийн талаарх ойлголт мэдлэгийг сайжруулах, албадан хөдөлмөрийн талаарх үндэсний бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, албадан хөдөлмөрийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээг сайжруулах, улмаар тэдний амьжиргааг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор судалгаа, шинжилгээний ажилд НҮБ техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Хүний эрхийг хүндэтгэн, хамгаалах чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхыг хөгжүүлэхэд НҮБ-аас Засгийн газарт дэмжлэг үзүүлэн ажиллаа. ХДХВ-ийн халдвартай хүмүүс болон хүн амын зарим бүлгийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах үзэгдэл гарсаар байгаа нь тэдний эрүүл мэндийн үйлчилгээ авах болон Монгол Улсын ДОХ-н өвчинтэй тэмцэх чиглэлээр гаргаж буй хүчин чармайлтад ахиц дэвшил гаргахад ихээхэн саад тотгор учруулж байна. ХДХВ-ийн халдвартай хүмүүсийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах үзэгдлийг арилгахад чиглэсэн сургалт, техникийн туслалцааг эрүүл мэнд, хууль шүүхийн байгууллагууд, олон нийтэд үзүүлэх замаар Монгол Улсад амьдарч байгаа ХДХВ-ийн халдварт өртсөн орхигдох эрсдэлтэй хүн амын эрүүл мэндийн эрхийг хамгаалахад НҮБ чухал үүрэг гүйцэтгэж байна.



**Үр дүн 4.2 Бодлогын үнэлгээг тогтмол хийх, нөлөөлөл, сурталчилгаа, сургалт мэдээллийн үйл ажиллагаа өргөжүүлэх зэргээр эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, дарамт шахалт, хүн худалдаалах гэмт хэрэг зэргээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, жендэрийн эрх тэгш байдлыг хангах механизм, үйл явцыг сайжруулна.**

Монгол Улсын Засгийн газар ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгах 12 тэргүүлэх чиглэлд жендэрийн эрх тэгш байдлыг хангахыг оруулж тодорхойлсон бөгөөд 2023 онд эмэгтэйчүүдийн манлайлал, эрэгтэйчүүдийн оролцоо, эрэгтэйчүүдийн хэвшмэл ойлголт хандлагыг шийдвэрлэхэд НҮБ тэргүүлэх ач холбогдол өгч ажилласан. НҮБ-ын техникийн болоод санхүүгийн дэмжлэгтэйгээр нийт салбарын бараг 50 хувийг хамруулж Жендэрийн эрх тэгш

байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх нь туйлын чухал болохыг олж тогтоосон. Улс орнууд төсөв, татварын бодлогоо шинэчилж жендэрийн эрх тэгш байдлын стандартыг хангах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд туслах НҮБ-ын тэргүүлэх санаачлага EQUANOMICS буюу Эдийн засгийг жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглүүлэх санаачилгыг дэмжин хэрэгжүүлэхээр Монгол Улсын Татварын Ерөнхий Газар (ТЕГ) Жендэрийн үндэсний хороотой хамтран ажиллаж эхэллээ. ТЕГ нь энэхүү санаачилгад нэгдэж буй тус улсын анхны төрийн байгууллага бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг хангах үүрэг амлалтаа бодит ажил хэрэг болгохын тулд байгууллагынхаа бүтэц хийгээд баримталж буй бодлого журамд гарч буй зөрүүг арилгахад эхлээд зохих алхмуудыг хийж байна.

2023 оны онцлох нэг ололт бол эрэгтэйчүүдэд зориулсан сэтгэл зүй-нийгмийн зөвлөгөө өгөх мэдээллийн төв байгуулах туршилтын төсөл юм. Тус төвөөр 200 гаруй иргэн, 22 хос үйлчлүүлэн хэрэгцээтэй мэдээллээ авч, сэтгэл зүйн болон хосуудад зориулсан зөвлөгөө авчээ. Төв, орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгмийн байгууллагуудад жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой нийгмийн хөрнөлөө бүхий хэмжээг шийдвэрлэх зэрэгт чиглэсэн өргөн хүрээтэй дэмжлэгийг НҮБ үзүүллээ. НҮБ-ын системийн байгууллагууд хамтран эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг тэмцэх агуулга бүхий 5 удаагийн кампанит ажлыг улс орон даяар зохион байгуулсан. Эдгээр кампанит ажлын хүрээнд мэдээ мэдээлэл түгээж, төрөл бүрийн үйл ажиллагаа, арга хэмжээ, хэлэлцүүлгүүд зохион байгуулсан бөгөөд эдгээр үйл ажиллагаанд 100 гаруй мянган хүн оролцсон. Түүнчлэн, хөвгүүд, эрчүүдэд зориулж жендэрт суурилсан хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, улмаар хэрхэн тэмцэх талаар зөв мэдлэг, ойлголт түгээх, жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсооход тэдний гүйцэтгэх үүрэг, оролцоо хэрхэн чухал болох талаар мэдлэг мэдээлэл өгөх 10 жижиг төслийг НҮБ-ын зүгээс хэрэгжүүлсэн. Үүнд 4,000 шахам хөвгүүд, эрчүүд хамрагдсан.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг илрүүлэх, тэдэнд тусламж үзүүлэх, түүнчлэн хороо, хэсэг, дүүрэг, сум, аймгийн түвшний тэргүүн шугамд ажиллаж буй албан тушаалтан, ажилтнуудаар дамжуулан шилжилт хөдөлгөөнтэй холбоотой нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэх зэрэг чиглэлээр хууль сахиулах байгууллага, үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхыг хөгжүүлэхэд НҮБ-аас дэмжлэг үзүүлж байна. Мөн хөдөө орон нутгаас шилжин

# Өөрчлөлтийн түүчээ эмэгтэй манлайлагчид



СХҮЙСИЙН ТАЛААР ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТУУДЫГ УЛАМ БҮР ДЭВЭРГЭЖ БАЙДАГ УЛАМЖЛАЛТ ОЙЛГОЛТЫГ СӨРӨН ЗОГСОЖ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ТҮҮЧЭЭЛЖ БУЙ ИРГЭНИЙ НИЙГМИЙН МАНЛАЙЛАГЧ Б. БАТЦЭЦЭГ, Б. ЦЭРЭНЛХАМ, Р. ОЮУНБИЛЭГ НАРЫГ ТАНИЛЦУУЛъя.

Тэд Монгол Улсад, тэр дундаа нийслэл Улаанбаатар хотод идэвхтэй үйл ажиллагаа явуулж, цаашид орон нутагт руу хүрээгээ тэлэхээр тэмүүлж буй “Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээ”-ний идэвхтэн гишүүд юм. Өдгөө 2,000 гаруй гишүүнтэйгээр орон даяар үйл ажиллагаагаа явуулж байгаа тус сүлжээ нь БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (КОЙКА) болон НҮБХХ-ийн хамтран хэрэгжүүлж буй төслийн санаачилгаар байгуулагдсан.

Сүлжээнд нэгдсэнээр эмэгтэйчүүдийн өөртөө итгэх итгэл улам бүр нэмэгдэж, нийгмийн хэм хэмжээ, хэвшмэл ойлголтуудтай идэвхтэй тэмцэж байна хэмээн Б.Батцэцэг хэллээ. Тэрээр сүлжээгээрээ дамжуулан эрэгтэй болон эмэгтэй хүйсийн аль алинд байдаг жендэрийн хэвшмэл ойлголтыг эвдэх чиглэлээр орон нутагтаа ажиллаж байна.

“Сүлжээнд хамрагдсанаар би өөрийнхөө манлайлах чадварт илүү итгэлтэй болж, улс төрд хандах хандлага маань эергээр өөрчлөгдөж байгаа” хэмээн Б.Цэрэнлхам онцлов.

Эмэгтэй хүн удирдлагын түвшний ажил эрэлхийлэх үед түүний гэр бүл, нэр хүндтэй холбоотой асуудлыг ярьж зүрх сэтгэлийг нь мохоохын оронд тэднийг дэмжин, “Чи чадна аа”, “Би чамайг дэмжинэ ээ” гэх мэт үгсээр нэг нэгнээ дэмжиж, урам зориг хайрладаг

хандлагатай байгаасай гэж Оюунбилэг үзэж байна.

Ийнхүү эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих олон төрлийн санаачилгуудаас гадна НҮБХХ-ийн төсөл нь УИХ-ын сонгуульд нэр дэвших аль нэг хүйсийн квотыг 2024 оны сонгуулиар 30 хувь, 2028 оноос эхлэн 40 хувиар тогтоох заалтыг батлуулахад томоохон дэмжлэг үзүүлэн ажилласан. Энэхүү өөрчлөлт нь улс төрийн намууд жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ хүйсийн харьцааг 1:1 болгох, улс төрийн намууд сонгуульд нэр дэвшигчдээс дэнчин, барьцаа авахыг хориглох зэргээр шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал дэмжлэг болж буй юм.





ирэгсдэд нийгмийн болоод хамгааллын үйлчилгээ хүргэх чиглэлээр орон нутгийн иргэний нийгмийн 17 байгууллагыг сургалтад хамруулж чадваржуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон сууцтай болох эрхийг хангахад чиглэсэн НҮБ-ын төслийн сургамжийн дагуу Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй орон сууцны төслүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийг аль болох олноор хамруулах, тэдний амьжиргаа, амьдралын чанарыг сайжруулах зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон сууцыг дэмжих хөтөлбөрийг батлуулсан.

**76.3%**

2024 оны улсын төсөвт хүүхэд хамгаалалд зарцуулах төсөв 76.3%-р нэмэгдэж үр дүнд суурилсан байдлаар боловсруулагдсан.



**NADP**

Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг үр дүнд суурилсан аргачлалаар боловсруулав.



**Үр дүн 4.3 Төв, орон нутгийн оролцогч талуудын үйлчилгээг ил тод, хүн төвтэй, үр нөлөө гарахуйцаар үр дүнтэй хүргэх чадавх дижитал хувьсалд**

**шилжсэнээр сайжирч; нотолгоонд суурилж бодлого боловсруулах, хяналт шинжилгээ хийх, тайлагнах үйл явцыг харилцан уялдуулж; бодлого шийдвэр гаргахад иргэд оролцох боломжийг бүрдүүлснээр тэд эрх баригчдаас үр дүнгийн хариуцлага нэхэх чадвар эзэмшсэн байна.**

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 7-р сард баталсан ТХЗ-ын Санхүүжилтийн таксономи (ангилал) баримт бичгийг боловсруулахад НҮБ дэмжлэг үзүүлэв. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл ийнхүү ТХЗ-ын Санхүүжилтийн таксономийг Монгол Улсын тогтвортой хөгжилд зориулсан санхүүгийн урсгалын нөлөөллийг хэмжих, баталгаажуулах, тайлагнах шалгуур үзүүлэлтүүдийн хамт баталсан нь бүтцийн болоод стратегийн томоохон өөрчлөлт болсныг тэмдэглэх нь зүйтэй юм. Тус төсөл нь үндэсний тогтвортой хөгжлийн тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох хувийн хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэн дайчлах зорилготой юм. Түүнчлэн, НҮБ-аас ҮСДИ-ийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн нь ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгах 12 тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход түлхэц болсон юм.

НҮБ нь Монгол Улсад үр дүнд суурилсан төсөвлөлтийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд өнгөрсөн оны хувьд бодлогын баримт бичиг боловсруулах заавар, удирдамжид тус аргачлалыг тусгасан болно. Тухайлбал, 2024 оны төсвийн төсөл боловсруулахдаа зургаан яам Үр дүнд суурилсан төсөвлөлт (ҮДСТ/RBB)-ийн аргачлалыг мөрдсөн. Түүнчлэн, үр дүнд суурилсан менежмент (ҮДСМ/RBM)-ийн аргачлалыг ашиглан яамдын түвшний үр дүнгийн үзүүлэлтүүдийг салбарын болон үндэсний хөгжлийн үр дүнгийн үзүүлэлтүүдтэй уялдуулж 2024 оны Үндэсний хөгжлийн жилийн төлөвлөгөө (ҮХЖТ)-нд тусгасан.

Түүнчлэн 2023 оны хагас жилийн хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэл, үр дүнгийн тайланг Монгол Улсад анх удаа туршилтаар хоёр салбар (ХХААХҮЯ, ХНХЯ) боловсруулж, хөтөлбөрийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн биелэлтийг санхүүгийн зарцуулалттай нь уялдуулж дүн шинжилгээ хийсэн. Мөн НҮБ нь хүүхэд хамгааллын төсвийг зохистой, үр дүнтэй, үр ашигтай гаргах талаар сурталчлан таниулах зорилгоор СЯ, ХНХЯ-тай нягт хамтран ажилласны үр дүнд 2024 оны хүүхэд хамгааллын төсвийг 76.3 хувиар нэмэгдүүлж, үр дүнд суурилсан төсөвлөлттэй уялдуулж чадсан. Түүнчлэн НҮБ нь хүн амын мегатрендийн нэг хэсэг болох Үндэсний шилжүүлгийн дансны (ҮШД/NTA) тухай ойлголтыг Монгол Улсын Засгийн газарт танилцуулсан бөгөөд энэ нь хөгжлийн төлөвлөгөө, бодлогод нөлөөлөх чухал хүчин зүйл болох юм. НҮБ нь тогтвортой хөгжлийн бодлогын уялдаа холбоог сайжруулахын тулд мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх дараах

төсөл хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлсэн. Тухайлбал, i). 2023 оны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа ii). 2017 оны Жендэрт суурилсан хүчирхийллийн тархалтын судалгаанд хийсэн гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ: Хамтран амьдрагчийнхаа зүгээс хүчирхийлэлд өртөх хамгаалалтын болоод эрсдэлт хүчин зүйлсийн шинжилгээ, iii) Малын ашиг шимийн хяналтын үндэсний тогтолцоог бий болгох аргачлал боловсруулах, ингэснээр малын ашиг шимийн жилийн хэлбэлзэлд тулгуурлан тайлагнадаг үндэсний тооцооны чанар сайжирна.

Түүнчлэн мэдээллийн нэгдсэн сан байгуулах, үнэлгээний чадавхыг бэхжүүлэх, хүүхэдтэй холбоотой мэдээлэл цуглуулах зэрэг чиглэлээр Үндэсний статистикийн хорооны чадавхыг хөгжүүлэхэд НҮБ дэмжлэг үзүүлэв. Мөн НҮБ нь МУИС-д жендэрийн статистикийн хичээлийн хэрэглэгдэхүүн боловсруулах, мөн ахисан түвшний сургалтын хөтөлбөрүүдэд “Жендэр судлал”-ын хөтөлбөрийг заавал оруулах зэрэг чиглэлээр техникийн туслалцаа үзүүлсэн. Үндэсний онцлогт нийцсэн ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах, үндэсний зорилтуудыг тодорхойлох, ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх механизмыг хөгжүүлэх, түүнчлэн хэрэгжүүлж буй бодлого, стратегиудад хэнийг ч орхигдуулахгүй байх зарчим хэрхэн хэрэгжиж байгаад дүгнэлт хийж хяналт тавих чадавхыг бэхжүүлэх зэрэг чиглэлээр НҮБ дэмжлэг үзүүлсэн. Эдгээр төслүүдэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хороо, Эдийн засаг, хөгжлийн яамны 50 гаруй мэргэжилтнүүд хамрагдсан.

Боловсролын салбарт мэдээлэл харилцаа технологийн ололтыг ашиглаж салбарын хэмжээний бодлого, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх чиглэлээр Боловсролын яамны институтын чадавхыг сайжруулахад НҮБ дэмжлэг үзүүлэв. НҮБ-аас Монгол Улсын Боловсролын салбарын Мэдээлэл харилцаа технологийн Мастер төлөвлөгөө, Багш нарын мэдээлэл харилцаа технологийн чадамжийг дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлэх, түүнчлэн хиймэл оюун ухааны технологийн ландшафтын суурь үнэлгээ хийх, тархаах, хиймэл оюун ухааны ёс зүйн зарчмуудыг хэрэгжүүлэх, хэвлэл мэдээллийнхний дижитал бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх зэрэг хиймэл оюун ухааныг тойрсон томоохон ажлуудыг хэрэгжүүлэхэд НҮБ дэмжиж ажиллаа. Түүнчлэн, үндэсний роуминг үйлчилгээг нэвтрүүлэх технологийн шийдлийг хөгжүүлэх замаар дижитал харилцаа холбоог өргөжүүлэн тэлэхэд НҮБ-аас дэмжлэг үзүүлж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутгийг хамрах хүрээг нэмэгдүүлэх боломж бүхий үндэсний роуминг ашиглан харилцаа холбооны үйлчилгээг хүн амд хүргэхэд шаардагдах хэрэгслээр засгийн газрын оролцогч талуудыг хангасан.

**4,000**

Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээгээр дамжуулан 4,000 эмэгтэй ур чадвараа нэмэгдүүлээд байна.



**25,918**

Нийт 25,918 залуучууд хэлэлцүүлэг, шийдвэр гаргалт, энхийг сахиулах үйл явцад биечлэн оролцоод байна.



**Үр дүн 4.4 Иргэний нийгэм, залуучуудын зөвлөлүүд, эмэгтэйчүүд, залуучуудын сүлжээдээр дамжуулан улсын болоод орон нутгийн хурлын сонгуулиуд, орон нутгийн бодлого шийдвэр гаргадаг байгууллагуудын эмэгтэйчүүд, залуучуудын төлөөлөл, оролцоог нэмэгдүүлнэ.**

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог хангах үүднээс сонгуультай холбоотой эрх зүйн актуудыг өөрчлөн шинэчлэхэд НҮБ-ын зүгээс багагүй дэмжлэг үзүүлсэн. Улс төрийн манлайлал болон сонгуулийн кампанит ажлыг хэрхэн зохион байгуулах талаарх сургалт зохион байгуулж сонгуульд нэр дэвших хүсэл эрмэлзэлтэй 1,000 гаруй эмэгтэйчүүдийг хамруулсан. НҮБ нь Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээтэй хамтран Монгол Улсын нийт аймгийн эмэгтэйчүүдийн төлөөлөөс бүрдсэн 4000 гаруй эмэгтэйчүүдийг сургалтад хамруулан чадавхыг нь дээшлүүлж эмэгтэйчүүдийн чадварлаг хүчийг бүрдүүлсэн. Түүнчлэн эмэгтэй удирдлагатай иргэний нийгмийн 14 байгууллагатай хамтран ажиллаж, чадавхыг нь сайжруулсан.

Залуучуудын оролцоог сайжруулахын тулд төрийн байгууллагууд, залуу удирдлагатай иргэний нийгмийн байгууллагууд болон НҮБ-ын системийн байгууллагуудын гурван талт бодлогын хэлэлцүүлгийн механизмыг НҮБ дэмжиж ирсэн. НҮБ-ын техникийн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр Залуучуудын хөгжлийн үндэсний чуулган зохион байгуулсан. Чуулганд 680 гаруй залуус биечлэн, 4500 гаруй залуус цахимаар оролцож Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа 2050”-ын хөгжлийн тэргүүлэх зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд салбар бүрийн харилцан хамтын ажиллагаа, түншлэл чухал болохыг онцлон тэмдэглэсэн. Чуулганаар Залуучуудын хөгжлийн тухай хуулийн хэрэгжилт, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх, тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтийн мэдрэмжтэй хөгжилд залуучуудын оролцоог өргөжүүлэх зэрэг олон чухал асуудлыг хөндсөн.

## 2.3 ТҮНШЛЭЛ, ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ 2030 ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖИХ

**Засгийн газартай хамтран ажиллах:** НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (НҮБ-ын ТХХАХ) нь Монгол Улс дахь НҮБ болон Монгол Улсын Засгийн газар хоорондын хамтран гарын үсэг зурж баталгаажуулсан хамтран хэрэгжүүлэх стратегийн баримт бичиг юм. Ийм ч учраас Монгол Улс дахь НҮБ нь ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгах, 2023-2027 оны НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газартай нягт хамтран ажиллаж байна. Монгол Улс дахь НҮБ нь Монгол Улсын Засгийн газарт хоёр дахь удаагийн Үндэсний сайн дурын илтгэл (ҮСДИ/VNR)-ээ бэлтгэж, нийтийн хүртээл болгоход нь идэвхтэй дэмжлэг үзүүлж түншлэлээ улам бататгасан. Түүнчлэн 2023 оны 7-р сард болсон ТХЗ-ын дээд хэмжээний чуулганд танилцуулсан хоёр дахь удаагийн ҮСДИ-ийн дүгнэлтийг үндэслэн үндэсний зорилтоо ахиулан тодорхойлох, ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгагч 12 тэргүүлэх чиглэлийг тодорхойлох чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт НҮБ мөн дэмжлэг үзүүлсэн. Ингэснээр олон талын оролцоог хангасан хэлэлцүүлгүүд болон ТХЗ-ын Үндэсний чуулганыг хамтран зохион байгуулж тус улсын ТХЗ-ын зорилтууд, ТХЗ-ын хурдасгуур хүчин зүйлүүдийг тодорхойлоход оролцогч талуудын идэвхтэй оролцоог хангаж чадсан.

Монгол Улс дахь НҮБ-ын дэмжлэгтэйгээр 2023 оны 3-р сард зохион байгуулагдсан НҮБ-ын Эмэгтэйчүүдийн аж байдлын комиссын 67 дугаар чуулганд Монголын төлөөлөгчид идэвхтэй оролцож, үндэсний илтгэлээ танилцуулсан. Монгол Улс дахь НҮБ нь Монгол Улсын дижитал хөгжил, худалдаа, эдийн засгийг төрөлжүүлэх, бүс нутгийн хөгжлийг ахиулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газартай хамтын ажиллагаагаа бэхжүүлж байна. Монгол Улс дахь НҮБ нь Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран Олон улсын цахим шилжилтийн яриа хэлэлцээ 2023 болон МХТ Үзэсгэлэн 2023: Mindgolia үзэсгэлэнг (Монгол инженерүүдийн ур ухаанаар бүтээгдсэн бүх төрлийн програм хангамжийн үзэсгэлэн) зохион байгуулсан. Мөн Гадаад харилцааны яамтай хамтран Монгол Улсын Цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээний (eTReady Assessment) тайланг боловсруулж нийтлүүлсэн. Түүнчлэн Монгол Улс дахь НҮБ нь Монгол Улсын Экспортын үндэсний стратеги (ЭҮС/NES) боловсруулж, ЭЗХЯ болон холбогдох бусад яам, агентлагуудтай хамтран экспортыг төрөлжүүлэх зорилгоор Дэлхийн экспортын хөгжлийн форум (WEDF) 2023-г зохион байгуулсан. Монгол Улс дахь НҮБ нь 2013 оны Ази Номхон Далайн бүс нутгийн Хүн амын VI бага хурлын үндэсний санал дүгнэлтийн хэрэгжилтийн талаарх Үндэсний сайн дурын илтгэлийг

боловсруулахад Засгийн газарт дэмжлэг үзүүлсэн. Тус илтгэлийг 2023 оны 11-р сард болсон Ази Номхон Далайн бүс нутгийн Хүн амын VII бага хуралд Засгийн газрын төлөөлөгчид оролцож танилцуулахад дэмжлэг үзүүлсэн. Монгол Улс дахь НҮБ нь Залуучуудын хөгжлийн үндэсний чуулган зохион байгуулахад Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлсэн ба тус чуулганд 680 гаруй залуус биечлэн, 4500 гаруй залуус цахимаар оролцож “Алсын хараа 2050”-ын хөгжлийн тэргүүлэх зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд салбар бүрийн харилцан хамтын ажиллагаа, түншлэл чухал болохыг онцлон тэмдэглэсэн.

**Хөгжлийн түншүүдтэй хамтран ажиллах:** Монгол Улс дахь НҮБ нь 2023 онд хөгжлийн түншүүдтэй хамтын ажиллагаагаа улам бэхжүүлж ажиллаа. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй суурин төлөөлөгчийн газартай хөгжлийн түншүүд болон олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран байгуулсан Хөгжлийн түншүүдийн бүлэг (ХТБ/DPG) болон эрчим хүчний асуудлаарх сэдэвчилсэн ажлын хэсэгтэй нягт хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж байгаагийн зэрэгцээ цахим хөгжлийн асуудлаар сэдэвчилсэн ажлын хэсэг байгуулах тухай хэлэлцүүлгийг эхлүүлээд байна. Монгол Улс дахь НҮБ нь дижитал хөгжил, худалдаа, эдийн засгийг төрөлжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Худалдаа, хөгжлийн чуулган (НҮБХХЧ/UNCTAD), Олон улсын худалдааны төв (ОУХТ/ITC), НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комисс (НҮБАНДЭЗНК) зэрэг Монгол Улсад суурин бус хөгжлийн түншүүд, НҮБ-ын системийн бусад байгууллагуудтай түншлэлийн харилцаагаа улам бүр өргөжүүлж байна.

**Хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах:** НҮБ-ын ТХХАХ-г хэр амжилттай хэрэгжүүлэх нь олон талын хамтын ажиллагаанаас хамаарах тул Монгол Улс дахь НҮБ нь хувийн хэвшил болон бусад оролцогч талуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлж байна. Тогтвортой, хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Монгол Улс дахь НҮБ нь Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Бизнесийн шударга байдлын төв, НҮБ-ын Даян дэлхийн гэрээ (ДДГ/UNG) ний албатай хамтран НҮБ-ын Даян дэлхийн гэрээний чуулганд хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулж мэдлэг ойлголтыг нь сайжруулах, чадавхжуулах хэд хэдэн арга хэмжээ зохион байгуулсан. Хувийн хэвшлийн тогтвортой бизнесийн дадал туршлагыг өргөнөөр сурталчилж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол Улс дахь НҮБ-

ын зүгээс Монгол Улсын Засгийн газартай хамтран зохион байгуулсан ТХЗ-ын Үндэсний чуулганд хувийн хэвшлийнхнийг урьж оролцуулан тэдэнд сайн туршлагаа олон нийтэд танилцуулах боломж олгосон. Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь монгол залуучуудын байгуулсан Сингапурт төвтэй уур амьсгалын технологийн гарааны компани URECA болон Гэр өргөө төрийн бус байгууллагатай хамтран “Гэр хороололд сэргээгдэх эрчим хүчний шилжилтийг дэмжих замаар амьжиргааг сайжруулах нь” төслийг хэрэгжүүлж байна. Түүнчлэн Монгол Улс дахь НҮБ нь Юнител компани болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хоорондын төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжсэнээр 10 аймгийн Залуучуудын хөгжлийн төвд Дижитал төвийг шинээр байгуулсан.

Эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор Монгол Улс дахь НҮБ нь Колумбын Их сургуулийн Олон улсын болон нийтийн харилцааны сургууль (SIPA)-тай тогтвортой хөгжлийн чиглэлээр судалгаа хийж байна. 2022/2023 онд Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд худалдааны чадавхыг ашиглах нь судалгааг сүүний салбарт; 2023/2024 онд тогтвортой бизнесийг дэмжих замаар Монгол Улс сэргээгдэх эрчим хүч рүү шилжих нь судалгаа хийсэн. Монгол Улс дахь НҮБ нь 2023 онд үндэсний их, дээд, дунд сургуулиудын хүчээр ТХЗ-ын нөлөөлөл сурталчилгааны олон ажил хийж хамтын ажиллагаагаа өргөжүүлж ажиллалаа. НҮБ-ын Суурин зохицуулагч болон Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын багийн гишүүд зарим их, дээд сургуулиудад зочлон (МУИС, МУБИС гэх мэт) тогтвортой, хүртээмжтэй хөгжлийн асуудлаар лекц, хэлэлцүүлэг өрнүүлсэн.

**Олон улсын болон үндэсний хүмүүнлэгийн байгууллагуудтай хамтран ажиллах:** НҮБ-ын Суурин зохицуулагч нь аливаа гамшиг тохиолдох үед Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэх зорилгоор НҮБ-ын системийн байгууллагууд, олон улсын болон үндэсний хүмүүнлэгийн байгууллагуудаас бүрдсэн Хүмүүнлэгийн тусламжийн Удирдлагын баг (ХТУБ/НСТ)-ийг тэргүүлдэг. Хүмүүнлэгийн тусламжийн Удирдлагын баг (ХТУБ/НСТ) нь шуурхай тусламж үзүүлж хүний амь насыг аврах зорилгоор 2024 онд Зудын эсрэг эрт хариу арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулж зудтай тэмцэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. Хүмүүнлэгийн тусламжийн Удирдлагын багийн гишүүдэд Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага, Монголын Улаан загалмай нийгэмлэг, Хүүхдийг Ивээх сан, АДРА Монгол ОУБ, Гүүд Нэйборс ОУТББ, Дэлхийн Зөн Монгол

ОУБ, Пипл ин Нийд Монгол ТББ зэрэг байгууллагууд орж байгаа бөгөөд хүмүүнлэгийн тусламжийг үндсэн нэгжид ажиллаж байгаа хүмүүс, эмзэг бүлгийн хүмүүст цаг алдалгүй хүргэхээр ажиллаж байна. Монгол Улсад 2023/2024 онуудад өвөлжилт ихээхэн хүндэрсэн тул ХТУБ-ийн гишүүд нягт хамтран ажиллаж, 2024 оны 2-р сарын 29-ний байдлаар хүмүүнлэгийн тусламжийн нийт 3.2 сая ам.долларын хөрөнгийг татан төвлөрүүлээд байна.

**Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах:** Монгол Улсын тогтвортой, хүртээмжтэй нийгмийг бүтээн байгуулах зам нь тэгш шударга, хэнийг ч орхигдуулахгүй байхыг дэмжих зорилгоор Монгол Улс дахь НҮБ нь иргэний нийгмийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна. 2023 онд зохион байгуулсан олон удаагийн зөвлөлдөх уулзалтууд нь Монгол Улс дахь НҮБ болон иргэний нийгмийн байгууллагууд хоорондын хоёр талын яриа хэлэлцээг хөгжүүлэх институцийн чухал механизм болсон. ТХЗ-ын хэрэгжилтийн талаарх хоёр дахь удаагийн Үндэсний сайн дурын илтгэл боловсруулах ажил, ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгах тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох зөвлөлдөх уулзалтууд, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (CRPD)-ийн Дүгнэлтийг хэрэгжүүлэх Үндэсний үйлажиллагааны төлөвлөгөөг боловсруулах зөвлөлдөх уулзалтууд зэрэг олон чухал үйл явдлуудад үндэсний иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулж байсан. Түүнчлэн эмзэг, орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдийн санал бодлыг сонсохын ач холбогдлын талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд Монгол Улс дахь НҮБ анхаарал хандуулж ирсэн. Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь Иргэний нийгмийн зөвлөлдөх хороо (ИНЗХ/CSACГХХХ)-оор дамжуулан иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тус хороо нь 2023 онд байгуулагдсан бөгөөд жендэрийн эрх тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, залуучуудыг эрх мэдлийг нэмэгдүүлэх, хэвлэл мэдээлэл, сэргээгдэх эрчим хүч, засаглал, хөдөөгийн хөгжил, байгаль орчин, цахим хөгжил, тогтвортой санхүүжилт зэрэг олон чиглэлээр мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллөөс бүрддэг. Монгол Улс дахь Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага нь тус улсын 11 аймагт шилжилт хөдөлгөөний чиглэлээр мэргэшсэн орон нутгийн 25 иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ болох MigNet-ийг байгуулж, гишүүдийнхээ шилжин суурьшигчдад шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлсний үр дүнд 2023 онд 30 мянга гаруй шилжин суурьшигчдад шууд тусламж, дэмжлэг үзүүлсэн байна.

## 2.4 НҮБ-ЫН НЭГДМЭЛ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН: НҮБ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРИЛЦАН УЯЛДАА, ҮР ДҮН, НӨЛӨӨ



НҮБ-ын ТХХАХ-г 2022 оны 5-р сард Монгол Улсын Засгийн газартай хамтран гарын үсэг зурж баталгаажуулсан бөгөөд 2023 оны 1-р сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлсэн. НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэх Хамтарсан ажлын төлөвлөгөө (ХАТ/JWP)-г 2023 оны эхний улиралд багтаан боловсруулж, Монгол Улсын Засгийн газартай Хамтарсан Удирдах Хороо (ХУХ/JSC) баталсан. ХУХ нь хүлээх үүргийнхээ дагуу 2023 онд НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэх дараах механизмыг тодорхойлон ажиллуулж эхэлсэн. ХУХ нь Монгол Улсын Засгийн газартай 2023 онд хоёр удаа уулзалт зохион байгуулж хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай танилцаж холбогдох дүгнэлт, шийдвэрийг гаргаж ажилласан.

2023 оны 3-р сар: Монгол Улс дахь НҮБ-ын 2022 оны Жилийн үр дүнгийн тайлан; Монгол Улсын Төлөв байдлын шинжилгээ 2022 (шинэчилсэн), ХАТ 2023, олон жилээр харуулсан санхүүжилтийн тооцооны хамт.

2023 оны 12-р сар: 2023 оны Хамтарсан ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явц; Дутагдалтай байгаа санхүүжилтийн тооцоо, нөөц дайчлах боломж, НҮБ-ын Хамтарсан хөтөлбөрүүд

2023 онд Үр дүнгийн бүлгүүд (RGs) улирал тутамд хуралдаж дараах асуудлыг хэлэлцсэн. Үүнд:

Хамтын ажиллагааны хүрээний хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх,

НҮБ-ын хамтарсан хөтөлбөрийн боломжит чиглэлүүдийг тодорхойлж, үндэслэл, үзэл баримтлалын төслийг боловсруулж эхэлсэн.

Сэдэвчилсэн багууд болон Хөтөлбөрийг дэмжих багууд тогтмол уулзалт зохион байгуулж (дийлэнх нь сар бүр) төлөвлөгөөт ажлуудынхаа гүйцэтгэл, явцыг хэлэлцэж байв. НҮБ-ын Суурин Зохицуулагчийн алба нь НҮБ-ын хамтарсан хөтөлбөрүүдийн хэрэгжилт, цаашид хамтарсан хөтөлбөрийн төсөл боловсруулах боломжуудын талаар санал солилцох зорилгоор Үр дүнгийн бүлгүүдийн өргөтгөсөн уулзалт (retreat)-ыг тусгайлан зохион байгуулсан. Үүний үр дүнд Монгол Улс дахь НҮБ нь дараах 12 сэдэвчилсэн чиглэлээр хэрэгжүүлэх боломжтой хамтарсан хөтөлбөрийн санал боловсруулж, төслийн үзэл баримтлалыг боловсруулан 2024 оны 3-р сард төлөвлөгдсөн ХУХ-нд танилцуулсан. Энэ уулзалтад зарим боломжит хандивлагчдын төлөөллийг ажиглагчаар урьж оролцуулсан.

2023 оны НҮБ байгуулагдсан тэмдэглэлт өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улс дахь НҮБ-ын Ордонд зочилсон нь Монгол Улс Тогтвортой хөгжлийн төлөө тууштай байгаагийн илэрхийлэл болсон.

Монгол Улс дахь НҮБ нь Монгол Улсын Төлөв байдлын шинжилгээг 2023 оны байдлаар шинэчилж, шинээр гарч ирж буй хөгжлийн сорилтуудад дүн шинжилгээ хийсэн. Энэ судалгаанд Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг онцлон тэмдэглэсэн бөгөөд 2023 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, Сонгуулийн болон улс төрийн намын тухай шинэ хууль батлагдсан зэрэг нь тус улсын улс төрийн нөхцөл байдлыг илэрхийлж байгааг тэмдэглэсэн. Мөн

шинжилгээнд хөдөө, хотын хөгжлийн ялгаа их байгааг онцолсон бөгөөд Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг бүс нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжих жил болгон зарлаж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж эхэлсэн.

НҮБ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний баг (ХШҮБ) болон НҮБ-ын Мэдээлэл харилцааны багийн нягт хамтын ажиллагааны үр дүнд Монгол Улс дахь НҮБ-ын 2022 оны Үр дүнгийн тайлан Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын дунд хамгийн шилдэг бөгөөд бүтээлч тайлангаар шалгарсан. Түүнчлэн, Монгол Улс дахь НҮБ-ын Хамтын ажиллагааны хүрээний хэрэгжилтэд НҮБ-аас хамаарах үр дүнгийн хэмжүүр болох хамтарсан үр дүнгийн 38 шалгуур үзүүлэлтийг (эдгээрийн 19 нь олон улсын үзүүлэлтийн системд орсон) тодорхойлсон бөгөөд улмаар ХШҮ-ний баг 2023 оны 10-р сард эдгээр үзүүлэлтүүдийн үндэслэл, тооцох боломжийг судалж цогц үнэлгээ хийсэн. Монгол Улс дахь НҮБ нь хамтарсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дайчлах хандивлагчдын зураглал гаргах, хамтын ажиллагааны хүрээг санхүүжүүлэх тус улсын нэгдсэн сан байгуулах боломжийг судлах зэрэг хөрөнгө нөөц дайчлах боломжуудыг тодорхойлох зорилгоор нөөцийг дайчлах хамтарсан стратеги боловсруулсан.

НҮБ-ын хамтарсан сэдэвчилсэн багууд (тухайлбал, Жендэр, Залуучууд, Хүний эрх) болон хөтөлбөрийг дэмжих багууд (тухайлбал, Хамтарсан мэдээлэл харилцааны болон захиргааны удирдлагын баг) нь хамтын ажиллагааны хүрээний үр дүнгийн холбогдох зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох буюу хувь нэмэр оруулах зорилгоор Үр дүнгийн бүлгүүдийн боловсруулсан тухайн жилийн тэргүүлэх чиглэлүүдийг үндэслэн зөвлөлдөх замаар хамтарсан ажлын төлөвлөгөөгөө боловсруулсан. Түүнчлэн залуучуудыг эрх мэдлийг нэмэгдүүлэхэд гол анхаарлаа чиглүүлж НҮБ-ын Суурин зохицуулагчийн манлайлал дор НҮБ-ын Залуучдын зөвлөлдөх хороо, залуу уран бүтээлчдийн дэмжлэгтэйгээр ахлах сургуулийн болон их дээд сургуулийн оюутнууд, орхигдох эрсдэлтэй орон нутгийн иргэдтэй хамтран ажиллаж, тэдэнд санал бодлоо чөлөөтэй илэрхийлж, өөрчлөлтийг өдөөгч хүчин болохоо мэдрэх боломжийг олгоход чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Дунд сургууль, их дээд сургууль, оюутны хотхонуудад НҮБ-ын Суурин зохицуулагч зочилж, хөгжлийн төлөө хамтын ажиллагааг идэвхжүүлэх, ТХЗ-ыг хэрэгжүүлэх үйлсийг манлайлах залуу үеийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан. Монгол Улс дахь НҮБ нь үндэсний болон олон улсын түвшинд ТХЗ-ыг таниулан манлайлах залуу үеийг дэмжихийн сацуу дэлхийн хөгжлийн хөтөлбөрт залуучуудын төлөөлөл нэн чухал болохыг онцлон тэмдэглэж байна.

НҮБ-ын Мэдээлэл харилцааны баг (UNCG) нь Монгол Улс дахь НҮБ-ын системийн хүрээнд олон нийтэд чиглэсэн нөлөөлөл сурталчилгааны хамтарсан хүчин чармайлтыг удирдаж, мэдээлэл түгээхээс гадна нэгдмэл хамтын үйл ажиллагааг дэмжиж байна. НҮБ-ын уриалгыг хүлээн авч, тогтвортой

хөгжлийн төлөө залуу манлайлагчдын тэргүүлсэн олон бүлэг нийгэмлэгүүд ТХЗ-ыг хэрэгжүүлэх үйлсийг хурдасгахад хувь нэмэр оруулах саналтай байгаагаа Монгол Улс дахь НҮБ-д хандаж илэрхийлсэн. НҮБ-ын Удирдлагын багийн Монгол Улсын ТХЗ-ын хэрэгжилтийг сурталчлах үйл ажиллагааны оргил үе нь ТХЗ-ын дээд хэмжээний чуулганы өмнөхөн буюу #Act4SDGs Даян дэлхийн тэмдэглэлт долоо хоногийн үеэр зохион байгуулсан ТХЗ-ын төлөө Үндэсний кампанит ажил байв. Энэ үеэр тал талаас цугларсан түмэн олонд зориулсан Видео сурталчилгааны том самбар, LED дэлгэцүүд, дижитал платформууд ажиллуулж үндэсний соёлын онцлогийг тусгасан ТХЗ нэг бүрийн таних тэмдгүүдийн дүрсүүд ашигласнаар кампанит ажил өвөрмөц хийгээд ард иргэдийн сонирхлыг татсан, мэдлэг мэдээлэл өгсөн, олон нийтийн хүчин чармайлтыг идэвхжүүлсэн үйл ажиллагаа болсон. Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүд, ялангуяа ТХЗ-ын төлөө сэтгүүлчдийн клуб, Эдийн засагч сэтгүүлчдийн клуб болон бусад хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлсэн нь Монгол Улс дахь НҮБ-ын хөгжлийн талаарх мэдээллийн найдвартай эх сурвалж болох нэр хүнд, итгэлийг нэмэгдүүлсэн.

2023 онд Захиргааны удирдлагын баг (OMT) нь Бизнесийн үйл ажиллагааны стратегийг (БҮАС/ВOS) хэрэгжүүлэх хүрээнд нийтлэг үйлчилгээ, урт хугацааны гэрээ хэлэлцээр (УХГ/LTAs)-ийн механизмыг хэрэгжүүлж системийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, үйл ажиллагааны зохицуулалтыг илүү сайн уялдуулах чиглэлээр хамтран ажилласан. БҮАС/ВOS-ийн Жилийн тайланд дараах нийтлэг үйлчилгээ хамрагдсаныг танилцуулсан. Эдгээр нийтлэг үйлчилгээнд ажлын байрны менежментийн нийтлэг үйлчилгээ, хамгаалалтын үйлчилгээ, хэвлэлийн үйлчилгээ, аялалын үйлчилгээ, бараа, үйлчилгээ нийлүүлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан, мэдээлэл харилцаа холбооны нийтлэг үйлчилгээ, тээврийн хэрэгслийн түрээсийн үйлчилгээ, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ зэрэг хамаарна. ТХЗ-ын хэрэгжилтэд нөлөөлөх нэмэлт үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй буюу хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлсэн худалдан авалтын үйлчилгээ, дадлагажигчид саадгүй мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлсэн мэдээллийн нэгдсэн санд зориулсан хүний нөөцийн нийтлэг үйлчилгээ зэрэг хамаарна. НҮБ-ын Удирдлагын баг нь бизнесийн үйл ажиллагааны стратеги (БҮАС)-д тусгагдсан нийтлэг үйлчилгээ нэг бүрийн хэрэгжилтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажилладаг бөгөөд БҮАС-тай холбоотой үйл ажиллагааг Захиргааны удирдлагын баг (OMT)-ийн Жилийн ажлын төлөвлөгөөнд нэгтгэн тусгаж төсвийг нь системийн байгууллагуудад тараан хуваарилж байна.

UN-Info мэдээллийн сан дахь Country Common Premises Plan (CCPP) платформыг хамтаар ашиглаж байгаа ажлын байрны нөхцөл байдал, тухайн байрны төслүүд, нийтлэг үйлчилгээг нэвтрүүлсний ашиг тус зэрэг 2023 оны холбогдох мэдээллээр баяжуулж шинэчилсэн.

## 2.5 ҮНЭЛГЭЭ, СУРГАМЖ

НҮБ-ын ХТХ-ний хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээг НҮБ-ын ХТХ-ний Хамтарсан Удирдах хорооны захиалгаар 2021 оны 8 дугаар сараас 2022 оны 2 дугаар сарын хооронд хийж, гүйцэтгэсэн билээ. Тус үнэлгээний тайлангаас гарсан гол зөвлөмжүүдийг ирэх 5 жил хэрэгжүүлэх ТХХАХ-нд үр дүнтэй тусгаж, хамтын ажиллагааны хүрээг амжилттай хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүллээ. Дараах хүснэгтэд зөвлөмжүүдийн дагуу авч хэрэгжүүлсэн гол арга, хэмжээг нэгтгэн харуулав.

Хүснэгт 2: НҮБ-ын ХТХ-ний Үнэлгээний тайланд өгсөн гол зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ

Гол зөвлөмж	Зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн ажил	Явц
Монгол Улсын Засгийн газар дараагийн хэрэгжих НҮБ-ын ТХХАХ-нд өөрийн хариуцах үүрэг, стратегийн менежментээ илүү бэхжүүлэх шаардлагатай.	НҮБ-ын ТХХАХ-ний стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг Засгийн газар,бусад оролцогч талуудтай хамтран боловсруулж, үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулсан. Засгийн газар болон НҮБ-ын Хамтарсан Удирдах Хороо (ХУХ) нь ирэх таван жилийн НҮБ-ын ТХХАХ-ний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	Хэрэгжсэн
	Ажлын удирдамжийн дагуу Хамтарсан удирдах хороо нь жилд хоёроос доошгүй удаа хуралдаж, НҮБ-ын ТХХАХ-ний хэрэгжилтийн явцад үнэлэлт дүгнэлт өгч, тус улсын болон бүс нутаг, олон улсын хөгжлийн нөхцөл байдалтай уялдуулан холбогдох арга хэмжээг авна. 2023 онд ХУХ нь 3-р сарын 17, 12-р сарын 11-ний өдрүүдэд хоёр удаа хуралдсан.	Хэрэгжиж байгаа (жилээр)
	Ажлын удирдамжид Үр дүнгийн бүлгүүд (RGs) нь улирал тутамд хуралдаж байхаар заасан. Үр дүнгийн бүлгүүд 2023 оны 12-р сарын 5-нд өргөтгөсөн уулзалт (retreat) зохион байгуулсан. Түүнчлэн 2023 онд Үр дүнгийн бүлгүүд гурван удаа хоёр талын уулзалт хийж хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хэлэлцсэн.	Хэрэгжиж байгаа (жилээр)
НҮБ-ын системийн байгууллагууд ТХХАХ-г үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд Үр дүнгийн бүлгүүд, Сэдэвчилсэн бүлгүүдийн хамтын ажиллагааг сайжруулж, үйл ажиллагааг нь Суурин зохицуулагч, Удирдлагын багт дэмжлэг үзүүлэхэд чиглүүлж ажиллах шаардлагатай.	НҮБ нь нэгдмэл, харилцан уялдаатай хүчин чармайлт гаргаж, НҮБ-ын ТХХАХ-ний зорилтот үр дүнд хүрэхийн тулд НТХХАХ-ний стратегийн тэргүүлэх чиглэл тус бүрээр НҮБ-ын Үр дүнгийн бүлгийг (RGs) байгуулсан. Түүнчлэн НҮБ-ын Үр дүнгийн бүлгүүдийг дэмжих зорилгоор Сэдэвчилсэн багууд, Хөтөлбөрийг дэмжих багуудыг байгуулсан. Сэдэвчилсэн багууд нь (1) Хүний эрх, (2) Жендэр, (3) Залуучууд; Хөтөлбөрийг дэмжих багууд нь (1) Хяналт шинжилгээ, үнэлгээ, сургалт (2) Мэдээлэл харилцаа, (3) Санхүүжилт, түншлэл (4) Захиргааны удирдлагын баг зэрэг болно.	Хэрэгжсэн
	2023 онд Мэдээлэл харилцааны баг нь Нэгдсэн стратеги боловсруулсан бол Хяналт шинжилгээ, үнэлгээний баг нь НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэхэд Үр дүнгийн бүлгүүдийг дэмжих зорилгоор Хяналт шинжилгээ, үнэлгээ, сургалтын төлөвлөгөөг боловсруулсан. Залуучуудын сэдэвчилсэн баг нь 2023-2027 онд хэрэгжүүлэх НҮБ-ын ТХХАХ-тэй уялдуулан залуучуудыг эрх мэдлийг нэмэгдүүлэх нь салбар хоорондын чухал ач холбогдолтой болохыг тэмдэглэн Ажлын даалгавраа шинэчилсэн. Улмаар Залуучуудын баг нь хамтарсан жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулсан. Жендэрийн баг нь Үр дүнгийн бүлгүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор дөрвөөс олон удаа уулзаж, асуудлаа хэлэлцсэн.	Хэрэгжиж байгаа (жилээр)
	Хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор НҮБ-ын системийн байгууллагууд нь Үр дүнгийн бүлгүүд (ҮДБ)- ийг ээлжлэн даргалахаар тохиролцсон. 2023 онд ҮДБ-1-ийг НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан (хамтран даргалсан), ҮДБ-2-ыг НҮБ-ын ХХААБ, АНДЭЗНК (хамтран даргалсан), ҮДБ-3-ыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, ОУХБ (хамтран даргалсан). 2024 онд ҮДБ-ийн дарга нар дараах байдлаар солигдоно. Үүнд: ҮДБ-1-ийг НҮБ-ын Хүн амын сан, ДЭМБ (хамтран даргална), ҮДБ-2-ыг НҮБ-ын Хүүхдийн сан, АНДЭЗНК (хамтран даргална), ҮДБ-3-ыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, ОУШХБ (хамтран даргална).	Хэрэгжиж байгаа (жилээр)

Гол зөвлөмж	Зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн ажил	Явц
НҮБ-ын Удирдлагын баг ТХХАХ-ний хэрэгжилтийг жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэхэд баримтлах зарчмыг дагаж мөрдөхөд чиглүүлэх.	Үр дүнгийн зорилтын түвшинд, нийт 22 үзүүлэлтийн 5 (23%) нь жендэрийн эрх тэгш байдалд гарсан өөрчлөлтийг илэрхийлнэ. Үр дүнгийн түвшинд, 39 үзүүлэлтийн 20 (51%) нь жендэрийн эрх тэгш байдлыг хангаж байгаа үйл явцыг илэрхийлнэ. Энэ нь нийт 61 шалгуур үзүүлэлтийн 25-ынх нь ерөнхий өөрчлөлтийг харуулж байгаа буюу НҮБ-ын системд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад мөрдөх стандартын доод хэмжээнд (UNCT SWAP minimum) хангаж байгаа эсэхийг илэрхийлнэ	Хэрэгжсэн
	НҮБ-ын систем дэх жендэрийн эрх тэгш байдлын UNCT-SWAP үнэлгээг 2023 оны 9-10 дугаар сард Монгол Улсад хийсэн. Жендэрийн сэдэвчилсэн баг нь Байгууллагууд хоорондын үнэлгээний баг (IAT)-ийн бүрэлдэхүүнд орсон бөгөөд үнэлгээний удирдамжийн дагуу бусад холбогдох зохицуулалтын механизмын төлөөллийг хангах зорилгоор нэмэлт гишүүдийг оруулсан. Энэхүү үнэлгээний үйл явц дөрвөн үе шаттайгаар өрнөсөн. Тухайлбал, Бэлтгэл, Өөрийн үнэлгээ, Үйл ажиллагааны төлөвлөлт, Эцэслэх гэсэн дөрвөн үе шаттай байв. Үр дүнгийн тайланг UNCT-SWAP платформд байршуулсан.	Хэрэгжсэн
	НҮБ-ын системийн байгууллагууд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг эрх мэдлийг нэмэгдүүлэх (GEWE) чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ИНБ-уудтай хамтран ажилладаг бөгөөд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах үүднээс хамтын ажиллагааны хүрээнд ийм санаачлагыг дэмжин ажиллаж байна. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн кампанит ажлын хүрээнд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүн амын сан зэрэг байгууллагууд үндэсний ИНБ-уудтай хамтран арга хэмжээ зохион байгуулсан.	Хэрэгжсэн
НҮБ-ын Удирдлагын баг болон Засгийн газар нь Үр дүнд суурилсан менежмент (ҮБХ) болон ХШҮ-ний тогтолцоог ашиглан НҮБ-ын ТХХАХ-г стратегийн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавих чадавха бэхжүүлэх.	НҮБ-ын ТХХАХ нь гүйцэтгэлийн хяналт, нөлөөллийн үнэлгээ хийх боломжийг олгох үр нөлөө, үр дүнгийн түвшний шалгуур үзүүлэлтүүдтэй.	Хэрэгжсэн
	2023 онд ХШҮ-ний баг нь НҮБ-ын системийн байгууллагуудын ХШҮ-ний үйл ажиллагааг зохицуулж НҮБ-ын ТХХАХ-г үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, сургалтын төлөвлөгөөг боловсруулсан. Хамтарсан ажлын төлөвлөгөөг тайлагнах, шинэчлэн сайжруулах удирдамжийг боловсруулсан.	Хэрэгжиж байгаа (жилээр)
	ХШҮ баг нь 2023 оны 11-р сард Үр дүнд суурилсан тайлан боловсруулах сургалтыг (жилийн эцсийн тайлан гаргах) хоёр удаа зохион байгуулсан. Сургалтад НҮБ-ын системийн 38 ажилтан хамрагдсан.	Хэрэгжиж байгаа (жилээр)
НҮБ-ын Удирдлагын баг нь аль болох гүйлгээний зардлыг бууруулах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх.	Бизнесийн үйл ажиллагааны стратеги (BOS)-ийг жил бүр хянаж үнэлгээ хийж байна. 2023 оны үнэлгээ 2023 оны 4-р сард дууссан.	Хэрэгжиж байгаа (жилээр)
	Бизнесийн үйл ажиллагааны стратеги (BOS)-ийн жилийн үнэлгээнд 2023 онд гурван төрлийн нийтлэг үйлчилгээ нэмэгдсэн.	Хэрэгжиж байгаа (жилээр)

## 2.6 САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГИЙН ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭЛТ

Хүснэгт 3: Санхүүжилт стратегийн тэргүүлэх чиглэлээр, (2023), (сая ам доллар)

СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	Нийт шаардлагатай	Татан төвлөрүүлсэн	Санхүүжилт	Төсвийн гүйцэтгэлийн хувь
Хүний хөгжил, сайн сайхан байдал	17.73	16.70	14.94	89.5%
Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлт	26.58	27.21	22.80	83.8%
Хүн төвтэй засаглал, эрх зүйт ёс, хүний эрх	7.66	7.58	7.04	92.9%
<b>Нийт дүн</b>	<b>51.97</b>	<b>51.49</b>	<b>44.78</b>	<b>87.0%</b>

2023-2027 оны НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэхэд ихээхэн хэмжээний санхүүжилт дутагдалтай байгаа тул Монгол Улс дахь НҮБ нь нөөц татан төвлөрүүлэх хамтарсан стратегийг боловсруулж Монгол Улсад тохирсон стратегийн санаачилга болгон хэрэгжүүлэхээр ажиллаж байна. НҮБ-ын Удирдлагын баг нь шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэхийн тулд хамтын ажиллагаа, харьцангуй давуу талаа ашиглан нэгдмэл зохицуулалттайгаар түншүүдтэйгээ нягт хамтран ажиллаж байна.

НҮБ-ын Удирдлагын багийн нэгдмэл зохицуулалттай хүчин чармайлт:

Стратегийн түвшинд, НҮБ-ын Удирдлагын баг нь Монгол Улсад НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг татан төвлөрүүлэх болон түншлэлийн стратегид тодорхойлсон алсын хараа, зорилт, үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ. Суурин Зохицуулагчийн зохицуулалтын дэмжлэгтэйгээр (шаардлагатай гэж үзвэл) НҮБ-ын Удирдлагын баг нь Засгийн газар, НҮБ-ын системийн гол хувь нэмэр оруулагчид болон стратегийн бусад түншүүдтэй нягт хамтран ажиллана.

Үйл ажиллагааны хувьд НҮБ-ын Санхүүжилт, түншлэлийн баг (СТБ/PRMG) нь санхүүжилтийн стратегийг хэрэгжүүлэх үйл явцад идэвхтэй үүрэг гүйцэтгэнэ. Санхүүжилт, түншлэлийн багийн дарга нь стратегийн заалтуудыг төлөвлөлт, хяналт шинжилгээний үйл явцад тусгах, хэрэгжүүлэх ажлыг бүхэлд нь хариуцна. Үүний тулд Санхүүжилт, түншлэлийн баг нь стратегийн хүрээнд нөөц татан төвлөрүүлэлтийн явц, дутагдаж буй санхүүжилт, гарч буй ахиц, цаашид авах арга хэмжээний стратеги зэрэгт чиглэсэн хэлэлцүүлгийг сар бүр зохион байгуулна.

НҮБ-ын Хамтарсан хөтөлбөрүүдэд хөрөнгө нөөц татан төвлөрүүлэх хүрээнд, НҮБ-ын Удирдлагын баг нь Санхүүжилт, түншлэлийн багийн дэмжлэгтэйгээр санхүүжилт авах боломжийг баталгаажуулах болон хамтарсан хөтөлбөрийн төслүүд нь хангалттай дэмжлэг авахаар хандивлагчдын ашиг сонирхол, тэргүүлэх чиглэлтэй нийцэж байгаа эсэхийг бататгахын тулд боломжит хандивлагчидтай стратегийн яриа хэлэлцээ өрнүүлнэ. Үр дүнгийн бүлэг бүр тус тусын хамтарсан хөтөлбөрийн төслийг боловсруулж дэмжих болон оролцох байгууллагуудыг тодорхойлж, тэргүүлэх чиглэлүүдийн үзэл баримтлал, стратегийг боловсруулна.

Хүснэгт 4: Санхүүжилт стратегийн тэргүүлэх чиглэлээр, байгууллагаар (2023), (сая ам доллар)

СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	Байгууллагууд	2023 Шаардлагатай	2023 Бэлэн	2023 Зарцуулалт	
Хүний хөгжил, сайн сайхан байдал	ХХААБ	0.30	0.30	0.30	
	ОУХБ	0.40	0.14	0.14	
	ОУШХБ	1.00	0.62	0.58	
	ОУЦХБ	0.01	0.01	0.01	
	НҮБ-ын ДОХ-ын НХ		Мөнгөн бус дэмжлэг		
	НҮБ АНДЭНК	0.02	0.02	0.02	
	НҮБ-ын БШУСБ	0.41	0.16	0.16	
	НҮБ-ын ХАС	3.32	3.32	1.60	
	НҮБ-Хабитат	0.10	0.10	0.10	
	НҮБ-ын ХС	9.79	9.69	9.69	
	ДЭМБ	2.38	2.35	2.35	
	Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлт	ХХААБ	4.29	4.29	4.29
		ХААХОУС	0.63	0.58	0.57
		ОУХБ	0.30	0.16	0.09
ОУШХБ		0.53	0.51	0.51	
ОУХТ		0.58	0.55	0.52	
ОУЦХБ		0.03	0.03	0.03	
НҮБ-ын ХХЧ		0.10	0.10	0.10	
НҮБ-ын ХХ		11.42	12.33	10.99	
НҮБ-ын ГЭББ		0.07	0.07	0.07	
НҮБ-ын БОХ		2.31	2.31	1.38	
НҮБ-ын АНДЭЗНК		0.42	0.42	0.42	
НҮБ-ын БШУСБ		0.11	0.07	0.07	
НҮБ-ын ХАС		0.16	0.16	0.16	
НҮБ-ын ХС		1.33	1.33	1.33	
НҮБ-ын АҮХБ	3.84	3.84	1.80		
ДЭМБ	0.47	0.47	0.47		
Хүн төвтэй засаглал, эрх зүйт ёс, хүний эрх	ХХААБ	0.15	0.15	0.15	
	ОУХБ	0.90	0.78	0.66	
	ОУШХБ	0.29	0.29	0.28	
	ОУЦХБ	0.02	0.02	0.02	
	ХЭДКГ		Мөнгөн бус дэмжлэг		
	НҮБ-Эмэгтэйчүүд		Мөнгөн бус дэмжлэг		
	НҮБ-ын ДОХ-ын НХ		Мөнгөн бус дэмжлэг		
	НҮБ-ын ХХ	2.84	2.96	2.57	
	НҮБ АНДЭЗНК	0.06	0.06	0.06	
	НҮБ-ын БШУСБ	0.15	0.07	0.07	
	НҮБ-ын ХАС	0.86	0.86	0.86	
	НҮБ-Хабитат	0.05	0.05	0.05	
	НҮБ-ын ХС	2.33	2.33	2.33	
	ДЭМБ	0.02	0.02	-	
<b>НИЙТ</b>		<b>52.0</b>	<b>51.5</b>	<b>44.8</b>	

Эх сурвалж: UN-info



## БҮЛЭГ 3

### НҮБ-ААС 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД



## СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1: ХҮНИЙ ХӨГЖИЛ, САЙН САЙХАН БАЙДАЛ

- Хүүхэд залуучуудад ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээг ойртуулж, тэдний дунд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх замаар хүүхэд, залуучуудад таатай экосистемийг бүрдүүлэх
- Боловсролын тухай шинэ хуулийн (Багц хууль) хэрэгжилтэд хувь нэмрээ оруулах
- Нийгмийн хамгааллыг өргөжүүлж, бүх нийтийг, нэн ялангуяа эмзэг бүлгийнхнийг хамруулах
- Ундны ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний цаг уурын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой шийдлүүдийг боловсруулах
- Сургуулийн хоолны хөтөлбөрийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах замаар хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах
- Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах механизмыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах

## СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2: НОГООН, ХҮРТЭЭМЖТЭЙ, ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ

- **Эрсдэлд тэсвэртэй, тогтвортой ажил эрхлэлт**
  - Сургалтын тогтолцоо, дижитал шилжилт/технологи
  - Залуучуудын хөгжил, ажил эрхлэлт, түүний дотор ур чадварыг төлөвшүүлэх, шийдвэр гаргахад залуучуудын оролцоог хангах
  - Эмэгтэйчүүд, шилжин суурьшигчид, орхигдох эрсдэлтэй бүлгүүдийн ажил эрхлэлт
  - Ногоон ажлын байрны боломжууд
  - Аюулгүй, мэдээлэлд суурилсан шилжилт хөдөлгөөн
- **Эдийн засгийн төрөлжилт ба хот, хөдөөгийн эдийн засгийн хөгжлийн тэнцвэртэй байдал**
  - Бүс, орон нутгийн хөгжил
  - Зах зээлийн өрсөлдөөн, нэмүү өртгийн сүлжээний хөгжил
  - Цахим, харилцаа холбооны дэд бүтэц
  - Далд эдийн засгийг хууль ёсны дагуу ажиллах боломжийг бүрдүүлэх
  - Цэвэр эрчим хүч, шилжилт
- **Тогтвортой, ногоон санхүүжилт**
  - Дэвшилтэт санхүүжилт
  - Тогтвортой, хүртээмжтэй төрийн дэмжлэг, хөтөлбөр, бодлогууд
- **Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах**
  - Нийтийн эрүүл мэнд ба уур амьсгалын өөрчлөлт
  - Малчин өрх болоод зорилтод бүлгүүдийн эрсдэлийг тэсвэрлэх чадвар
  - Байгалын нөөцийн тогтвортой удирдлага, биологийн олон янз байдал ба байгаль хамгаалал

## СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3: ХҮН ТӨВТЭЙ ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙТ ЁС, ХҮНИЙ ЭРХ

- **Хүний эрхийг хамгаалах, дэмжих болон хүний эрхийн зөрчлийн хяналт**
  - Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, мөрдүүлэх, ОУХБ-ын Хөдөлмөрийн конвенцийг соёрхон батлах, хэрэглэх, хэрэгжүүлэх
  - Орхигдох эрсдэл бүхий эмзэг бүлгийн хүн ам, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрхийг хангах нотолгоо суурилсан бодлого, хөтөлбөр боловсруулах
  - Хүний эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, шүүх, хууль сахиулах байгууллага, Хүний эрхийн үндэсний комиссын чадавхыг нэмэгдүүлэх
- **Хүчирхийлэл, дарамт шахалтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах механизм**
  - Хүүхэд хамгаалал, хүн худалдаалах гэмт хэрэг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мэдээлэх, шийдвэрлэх талаар мэдлэг, чадавх, өгөгдөл, тодорхой хариуцлагын тогтолцоог сайжруулах
  - Жендэрийн асуудлыг бодлогод тусгах үндэсний болон орон нутгийн шийдвэр гаргачдын чадавхыг нэмэгдүүлэх
- **Нотолгоонд суурилсан бодлого боловсруулах, хяналт тавих, тайлагнах; хариуцлагыг сайжруулах**
  - Өгөгдөл, нотлох баримт бүрдүүлэх, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, бодлого боловсруулахад ашиглах
  - Төрийн үйлчилгээ, бодлого боловсруулах, хяналт тавих, хариуцлагын тогтолцоонд төрөл бүрийн дижитал хэрэгсэл, бүтээгдэхүүн, платформыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх
  - Үр дүнд суурилсан, үндэсний нэгдсэн төлөвлөлт, төсөв боловсруулахад төрийн байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэх
  - Илүү ил тод, хариуцлагатай байх нөхцөлийг бүрдүүлэх бизнесийн практикийг бэхжүүлэх
- **Эмэгтэйчүүд, залуучуудыг чадавхжуулах**
  - Улс төр, төрийн албанд эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоог нэмэгдүүлэх
  - Залуучуудын ур чадварыг хөгжүүлэх, тэдний манлайлал, оролцоог хангах боломжийг нэмэгдүүлэх

# ХАВСРАЛТ:

## Үр дүнгийн зорилт 1:

Шалгуур үзүүлэлтүүд	Суурь түвшин	2023 оны гүйцэтгэл	2027 оны зорилт	Баталгаажуулах арга хэрэгсэл
Үндэсний ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувь, бүс нутаг, аймгаар	27.8% (2020)	27.1% (2022) <sup>1</sup>	20%	ҮСХ, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа.
Хүнсний аюулгүй байдал нь дунд болон хүнд хэлбэрийн алдагдалд орсон өрхүүдийн нийт хүн амд эзлэх хувь	26.18%(2018-2020)	Байхгүй[2]	23.80%	Хүн амын хүнсний бодит хэрэглээний судалгаа, ШУТИС, ҮСХ, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны өрхийн хүнсний хэрэглээний хэсэг.
Эхийн эндэгдэл (100,000 амьд төрөлтөд ногдох)	30.12 (2020)	26.40%	20	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан ХН-201, Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ)
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд ногдох)	14 (2020)	14.8	12	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан ХН-201, Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ)
(i) Унших болон (ii) тоо бодох наад захын чадвар эзэмшсэн (a) 2/3-р ангийн сурагчид, (b) бага сургууль төгсөх ангийн сурагчид, (c) бүрэн бус дунд боловсрол эзэмших төгсөлтийн ангийн хүүхэд, залуучуудын эзлэх хувь, хүйсээр	2/3-р анги Унших бүгд 44.4% (2018) Эр 42.8 (2018) Эм 46.2% (2018) Тоо бодох Бүгд 33.6% (2018) Эр 34.9% (2018) Эм 32.2% (2018) Бага сургуулийн төгсөх анги, Унших Бүгд 67.0% (2018) Эр 68.0% (2018) Эм 66.2% (2018) Тоо бодох Бүгд 61.3% (2018)	Байхгүй[3]	48.4% 46.8% 50.2% 37.6% 38.9% 36.2% 70% 70% 70% 63% 67% 60%	Чанарын үнэлгээ, Боловсролын үнэлгээний төв (ЕАС), Нийгмийн үзүүлэлтүүдийн түүвэр судалгаа, ҮСХ

[1] Дэлхийн банк болон ҮСХ-ны мэдээлснээр үзүүлэлтийг тооцох аргачлал бүхэлдээ шинэчлэгдсэн учир 2022 оны үр дүнг 2020 оныхтой харьцуулах боломжгүй.

[2] Мэдээлэл 2024 оны 4-р сард бэлэн болно.

[3] Нийгмийн үзүүлэлтүүдийн түүвэр судалгаа, ҮСХ-ны мэдээлэл 2024 онд гарна, НҮТС.

## Үр дүнгийн зорилт 2:

Шалгуур үзүүлэлтүүд	Суурь түвшин	2023 оны гүйцэтгэл	2027 оны зорилт	Баталгаажуулах арга хэрэгсэл
Нийт эрчим хүчний эцсийн хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	3.4% (2018) [Дэлхийн банк]	3.7% (2022) [Эх сурвалж: НҮБ АНДЭНК ТХЗ-н тайлан IEA <a href="https://www.iea.org/countries/mongolia/energy-mix">https://www.iea.org/countries/mongolia/energy-mix</a> ]	12.0%	БОАЖЯ/ТХЗ-ын мэдээллийн сан
Зэрэгцүүлэх үнээр тооцсон нэг ажилтанд ногдох ДНБ-ий жилийн өсөлт	6.3% (2020)	0.41% (2022) [Эх сурвалж: ҮСХ]	4.2%	ҮСХ/ТХЗ-ын мэдээллийн сан
Ажилгүйдлийн түвшин (хувиар), байршил, хүйс, нас, хөгжлийн бэрхшээлийн статусаар	7% (2020) Хүйсээр, Эм: 6.7%, Эр: 7.3%, Байршлаар Хот: 8%, Хөдөө: 4.6%, Насны бүлгээр: 15-24: 17.9%, 25-64: 5.9%, Хөгжлийн бэрхшлийн статуссаар: хөгжлийн бэрхшээлтэй: 7%, хөгжлийн бэрхшээлгүй: 7.2%	6.7% (2022) Хүйсээр: Эмэгтэй: 5.8% Эрэгтэй: 7.4% Байршлаар: Хот: 7.9% Хөдөө: 3.9% Насны бүлгээр: 15-24: 12.9% 25-64: 6.4% Хөгжлийн бэрхшээлийн статус: Хөгжлийн бэрхшээлтэй: 12% бэрхшээлгүй 6.6% [Эх сурвалж: ҮСХ]	Суурь түвшнээс бага	<a href="https://www.nso.mn/mn/statistic/statcate/573065/table-view/DT_NSO_0400_020V2">https://www.nso.mn/mn/statistic/statcate/573065/table-view/DT_NSO_0400_020V2</a>
ДНБ-д боловсруулах үйлдвэрлэлийн нэмүү өртгийн эзлэх хувь	ДНБ-д эзлэх хувь: 10.8% (2019) [НҮБАҮХБ] Нэг хүнд ногдох: 900 мян.төг (2020)	ДНБ-д эзлэх хувь: 8.2% (2022) нэг хүнд ногдох: MNT 701,500 (2022) [Эх сурвалж: ҮСХ]	19.0%	ҮСХ/ТХЗ-ын мэдээллийн сан
ДНБ-д Судалгаа, хөгжүүлэлтийн салбарын зардлын эзлэх хувь	0.55% (2020)	0.32% (2022) [Source: NSO]	2.5%	NSO/SDG Dashboard
Цахим-Засаглалын хөгжлийн индекс	Байр: 92 0.6497	0.7209, нийт 193 орноос 74-т (2022)	Суурь түвшнээс өндөр	Цахим-Засаглалын хөгжлийн индекс судалгаа

## Үр дүнгийн зорилт 3:

Шалгуур үзүүлэлтүүд	Суурь түвшин	2023 оны гүйцэтгэл	2027 оны зорилт	Баталгаажуулах арга хэрэгсэл
Орон нутгийн хүн амын бүлгүүдийн эрсдэл даах чадавхын индекс	40.7	40.7 (2023 онд өгөгдөл байхгүй)	58.7	ХХААБ
Нийт газар нутагт ойгоор бүрхэгдсэн газар нутгийн эзлэх хувь	7.9% (2019)	7.74% (2022) [Эх сурвалж: ҮСХ]	8.7%	<a href="http://sdg.gov.mn/Goal/?id=15">http://sdg.gov.mn/Goal/?id=15</a>
Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эх болон, хуурай газар нутаг, цэнгэг усны биологийн олон янз байдлын томоохон газруудын эзлэх хувь, экосистемийн төрлөөр	Тусгай хамгаалалттай газар нутаг: 17.4%, Усны сав газар: 44.75%, Ойн сан бүхий газар: 36.8% (2015)	Тусгай хамгаалалттай газар нутаг: 21%, Усны сав газар: 50%, Ойн сан бүхий газар: 42.3%, Уул, уулархаг газар: 24.7%, (2022), [Эх сурвалж: ҮСХ]	Тусгай хамгаалалттай газар нутаг: 27% Усны сав газар: 55% Ойн сан бүхий газар: 48.7%	БОАЖЯ
Нийт газар нутагт доройтолд орсон газар нутгийн эзлэх хувь	Нийт 76.96% (2020)	Нийт 76.96% (2020)	Нийт 75%	Link

# ХАВСРАЛТ:

## Үр дүнгийн зорилт 4:

Шалгуур үзүүлэлтүүд	Суурь түвшин	2023 оны гүйцэтгэл	2027 оны зорилт	Баталгаажуулах арга хэрэгсэл
Шийдвэр гаргах үйл явц хүртээмжтэй, хариуцлагатай гэдэгт итгэдэг хүн амын эзлэх хувь	57.1 (2019)	35.5 (2022)	65.8	Батлагдсан мета мэдээллийн санг ашиглаж хийсэн Удирдлагын академиҮндэсний статистикийн хорооны хамтарсан судалгаа
Олон улсын хүний эрхийн хуулиар хориглосон ялгаварлан гадуурхах явдлын аль нэг тохиолдлоор сүүлийн 12 сард гадуурхагдсан, доромжлуулснаа мэдэрсэн хүн амын эзлэх хувь, эрхийн төрлөөр	17.7 (2019)	16.45 (2022)	Суурь түвшнээс доогуур	Монгол Улсын ТХЗ-ын мэдээллийн сан
16.b.14.2 (a) Олон улсын хүний эрхийн хуулиар хориглосон ялгаварлан гадуурхах явдлын аль нэг тохиолдлоор сүүлийн 12 сард гадуурхагдсан, доромжлуулснаа мэдүүлсэн хүн амын эзлэх хувь	4.5 (2019)	N/A	Суурь түвшнээс өндөр	
Эрх зүйт ёсны индекс	45.67 (2020)	45.75 (2022)	Суурь түвшнээс доогуур	Интерактив мэдээллийн хандалт Дэлхийн улс орнуудын засаглалын үзүүлэлтүүд (worldbank.org)
(a) УИХ болон (б) орон нутгийн Засаг захиргааны нийт суудалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь	17% болон 27%	хамаарахгүй	24.6% and 37.4%	Үзүүлэлтийн үр дүн 2024 оны 6-р сард болох УИХ-ын сонгуулийн дараа гарна
Авлигын төсөөллийн индекс	35 (2020) 111 (эрэмбэ)	33 (2022) 116 (эрэмбэ)	38, 94 (эрэмбэ)	Mongolia - Transparency.org
Залуучуудын хөгжлийн индекс (ерөнхий оноо)	0.758 (2020)	хамаарахгүй	Суурь түвшнээс өндөр	Дэлхийн залуучуудын хөгжлийн индекс 2022

## Гарцын түвшний үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлтүүд	Суурь түвшин	2023 оны гүйцэтгэл	2027 оны зорилт
Хүний папилломе вирус (ХПВ)-ын эсрэг вакцинд хамрагдвал зохих насны охидын ХПВ вакцинд хамрагдалтын хувь	1 хувиас бага	1 хувиас бага	1 хувиас бага
Хүний эрхийн стандартын дагуу хоол тэжээлийн бодлого, биеийн тамирын дасгал хөдөлгөөн, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, халдварт болон халдварт бус өвчин зэрэг эрүүл мэндийн ерөнхий болоод тусгай мэргэжлийн салбарыг хамруулсан эрүүл мэндийн асуудлаарх НҮБ-ын дэмжлэгтэйгээр боловсруулж, баталсан үндэсний бодлогын баримт бичгийн тоо	4	5	2
Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ (ЭМАШТУ/PHC) үзүүлэх чиглэлээр НҮБ-ын дэмжлэгтэйгээр нэмэгдүүлсэн хүчин чадал	14	25	14
Хүний эрхийн олон улсын стандартад нийцсэн, хүртээмжтэй, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан боловсролын тогтолцоог бэхжүүлэхэд НҮБ-ын үзүүлсэн дэмжлэг	2	2	2
Ур чадвар, насан туршийн боловсрол, бэлгийн цогц боловсрол (БЦБ) зэрэг хөтөлбөрүүдийг НҮБ-ын дэмжлэгтэйгээр боловсруулж хэрэгжүүлэн хүртээмжийг сайжруулснаас шууд ашиг тус хүртэж буй хүний тоо	0	46027	50000
Нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөжүүлэх, цогц байдлыг сайжруулах, тэтгэвэр тэтгэмжийн зохистой харьцааг тогтоох чиглэлээр НҮБ-ын дэмжлэгтэйгээр шинээр буюу шинэчлэн боловсруулсан үндэсний нийгмийн хамгааллын бодлогын баримт бичгийн тоо	0	2	0
Ядууралд өртсөн (хөдөөгийн) хүмүүсийг эрх мэдэлжүүлэх болон үйлдвэрлэлийн нөөц, үйлчилгээ, технологи, зах зээлд нэвтрэхэд нь ядуу эрэгтэй, эмэгтэй хүмүүст тулгарч буй саад бэрхшээлийг арилгах чиглэлээр НҮБ-ын дэмжлэгтэйгээр шинэчилж сайжруулсан үндэсний бодлого, зохицуулалтын тоо	Үгүй	Боловсруулж байгаа	Үгүй
Хүний эрхэд суурилсан, жендэр, ялгаатай байдал, хөгжлийн бэрхшээл, насны онцлог зэрэгт тохирсон нийгмийн хамгааллын бодлого хэрэгжүүлэх чадавха НҮБ-ын дэмжлэгтэйгээр бэхжүүлсэн байгууллагын тоо	0	1	1
Хүчирхийлэл, мөлжлөг, доромжлол, хайхрамжгүй байдалд зэрэгт өртөж, НҮБ-ын дэмжлэгтэй хөтөлбөр хэрэгжүүлж байгаа эрүүл мэнд, нийгмийн ажил, эрх зүйт ёс/хууль сахиулах албадын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	6477	14299	3523
НҮБ-ын дэмжлэгтэй уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, жендэрийн мэдрэмжтэй (a) аюулгүй ундны ус, (б) сайжруулсан ариун цэврийн байгууламж, (в) хог хаягдлын менежментийн үйлчилгээ, (г) эрүүл ахуйн үйлчилгээ авч буй өрх/байгууллагын тоо	0	a)8366, b)10487 (8412+2075), c) 5 HCFs d) 8544	a) 1000, b) 1000, c) 5 HCFs, d) 1000
Хүний эрхийн олон улсын стандартад нийцсэн, хүртээмжтэй ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламж (WASH)-ийн өртгийн тооцоог НҮБ-ын дэмжлэгтэйгээр боловсруулж, хэрэгжүүлсэн санхүүжилтийн стратеги.	0 (мэдээлэл байхгүй)	Боловсруулсан	Боловсруулсан
Хүн амыг хоол тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх, эмчлэх, хоолны дэглэмийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж буй НҮБ-ын хөтөлбөрт хамрагдсан шим тэжээлийн дутагдалтай эмзэг бүлгийн хүн амын тоо	400400	362860	328000
Өлсгөлөн, хүнсний аюулгүй байдал алдагдах, бүх төрлийн хоол тэжээлийн дутагдал зэргийг таслан зогсоох чиглэлээр НҮБ-ын дэмжлэгтэйгээр шинээр болон шинэчлэн боловсруулсан салбарын болоод салбар дундын бодлого, стратеги, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тоо	Үгүй	Боловсруулж байгаа	Үгүй

Эх сурвалж: UN-info

# ХАВСРАЛТ:

## Гарцын түвшний үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлтүүд	Суурь түвшин	2023 оны гүйцэтгэл	2027 оны зорилт
НҮБ-ын дэмжлэгтэйгээр Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах тухай хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, санаачлагыг хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлсэн байгууллагын тоо: а) Үндэсний аж ахуйн нэгж; б) Орон нутаг дахь аж ахуйн нэгж; в) Иргэний нийгмийн байгууллага (ИНБ); г) хувийн хэвшил.	0	19	19
Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр НҮБ-ын дэмжлэгтэй үйлчилгээнд (сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэц-нийгмийн дэмжлэгтэй холбоотой үйлчилгээ) хамрагдсан эмэгтэйчүүд, өсвөр үеийнхэн, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, залуучуудын тоо	5392	4037	4000
НҮБ-ын дэмжлэгтэй техник, мэргэжлийн боловсрол, сургалтын (ТМБС) болон дижитал ур чадварын сургалтад хамрагдсан залуучуудын тоо (эрэгтэй/эмэгтэй)	0	1560	1500
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаарх тусгайлсан стратеги, аль эсвэл үндэсний хөдөлмөр эрхлэлтийн стратегийн нэг хэсэг болгон боловсруулж, хэрэгжүүлсэн үндэсний стратеги байгаа эсэх (НҮБ-ын дэмжлэгтэйгээр боловсруулж хэрэгжүүлсэн)	Үгүй	Үгүй	Үгүй
Санхүүгийн зах зээлд байгаль орчны тогтвортой байдал, хаягдалгүй эдийн засгийг нэвтрүүлэх зорилгоор НҮБ-ын дэмжлэгтэйгээр байгаль орчны талаарх тоо мэдээлэл, дижитал хувьслын арга барилыг ашиглаж байгаа аж ахуйн нэгж, түншлэл, сүлжээ, бодлого, үйл ажиллагааны тоо	0	1	1
НҮБ-ын дэмжлэгтэйгээр бизнес эрхлэх чадавха сайжруулж, орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааг хөгжүүлэх техникийн ур чадвартай болсон хүмүүсийн тоо	0	1200	725
НҮБ-ын дэмжлэгийг дараах чиглэлээр авсан хүний тоо: а) Цэвэр, хямд, тогтвортой эрчим хүчний эх үүсвэртэй болсон; б) Цэвэр, хямд, тогтвортой эрчим хүчний үйлчилгээнээс ашиг тус хүртэж байгаа	0	3824	4000
Парисын хэлэлцээрийн дагуу Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт (ҮТХН)-ыг сайжруулах/ хэрэгжүүлэхийг эрчимжүүлэх зорилгоор НҮБ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ	1	2 (хэрэгжиж байгаа)	2 (хэрэгжиж байгаа)
НҮБ-ын дэмжлэгтэйгээр Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд зориулсан төсвийн хуваарилалт зэрэгт хяналт тавих боломж олгох үндэсний төсвийн төлөвлөлтийн тогтолцоог ТХЗ-той нийцүүлж буй байдал	Дунд зэрэг (12 ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг үндэсний 9 хөтөлбөрт тусгасан)	Дунд зэрэг (18 үзүүлэлтийг 2024 оны Төсвийн хуульд тусгасан)	Дунд зэрэг (24 үзүүлэлтийг Төсвийн хуулийн 1-р хавсралтад оруулсан)
Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны суурь баримт бичигтэй уялдуулсан НҮБ-ын дэмжлэгтэйгээр боловсруулан баталж, Засгийн газрын хэрэгжүүлж байгаа Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратегитай эсэх.	Үгүй	Боловсруулж байгаа	Үгүй
Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах, байгаль орчныг хамгаалах чиглэлээр НҮБ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр шимийг хүртэж буй хот, суурин газруудад амьдарч буй хүн амын тоо	0	92582	89439
Хөдөө аж ахуйн салбарын бүтээмж, цэвэр орлого, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах бодлого, стратеги, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх чадавха НҮБ-ын дэмжлэгтэйгээр сайжруулсан хөдөө орон нутгийн байгууллага, төрийн байгууллага болон бусад холбогдох оролцогч талуудын тоо	0	1	2
Орон нутгийн хүн амын амьжиргааг сайжруулахад чиглэсэн дасан зохицох буюу Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн менежмент (CRM)-ийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх орон нутгийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр НҮБ-ын хөтөлбөрт хамрагдсан орон нутгийн зорилтот байгууллагын тоо	50	9	10

## Гарцын түвшний үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлтүүд	Суурь түвшин	2023 оны гүйцэтгэл	2027 оны зорилт
НҮБ-ын дэмжлэгтэйгээр ган/усны аюулын эрсдэл, уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх чадварыг нь сайжруулсан газар тариалангийн талбай (га)	0	2500	4585
Байгаль хамгаалах, нөөцийн тогтвортой ашиглалтыг дэмжих НҮБ-ын хөтөлбөрүүдээс шууд ашиг тус хүртэж буй хүний тоо	0	28371	31000
НҮБ-ын дэмжлэгтэйгээр хамгаалалтад авсан буюу менежментийг нь сайжруулсан хуурай газрын болон далай тэнгисийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ (га)	20	49	10
Хүний эрхийн олон улсын стандартын хэрэгжилтийн түвшинг илэрхийлэх хүний эрхийн хяналт, хариуцлага, хамгаалалтын механизм, ялангуяа иргэний орон зайн хамгаалалт НҮБ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй эсэх.	Хэсэгчлэн	Хэсэгчлэн	Хэсэгчлэн
Хөдөлмөрийн харилцаан дахь хүний эрхийн олон улсын хэм хэмжээ, стандарт, ялангуяа ажлын байран дахь суурь зарчмууд, эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр НҮБ-ын дэмжлэгтэйгээр боловсруулсан хууль эрх зүйн баримт бичиг бий эсэх	Үгүй	Тийм	Тийм
Нийгмийн хор нөлөөтэй хэм хэмжээ, хүйсээр ялгаварлан гадуурхсан ажил үүрэг, дадлыг шийдвэрлэх замаар жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулсан НҮБ-ын дэмжлэгтэй санаачилгын тоо	0	5	2
Хүүхдийн хөдөлмөр, хүн худалдаалах гэмт хэрэг, албадан хөдөлмөр зэргээс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх зорилгоор НҮБ-аас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт хамрагдсан хүний тоо	0	6	0
Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ)-ын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, тогтвортой хөгжлийн төлөөх бодлогын уялдааг сайжруулах чиглэлээр НҮБ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх механизм, санаачилга	Дунд	Дунд (тоо, мэдээллийн ашиглалтыг удирдахад дэмжлэг үзүүлж, НҮТС-ны асуулга боловсруулсан)	Дунд (тоо, мэдээллийн ашиглалтыг удирдахад дэмжлэг үзүүлж, НҮТС-ны асуулга боловсруулсан)
НҮБ-ын дэмжлэгтэйгээр боловсруулсан Үндэсний Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ)-ын санхүүжилтийн стратеги бий эсэх	Үгүй	Үгүй	Тийм (ҮНСС/INFS-г батлана)
Хариуцлага (нийгмийн хариуцлага хамаарна)-ын тогтолцоог бэхжүүлэх, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, авлигатай тэмцэх ажлыг төрийн санхүүгийн удирдлага, төрийн үйлчилгээ, бусад салбаруудын үйл ажиллагаатай уялдуулах, тухайлбал, а) үндэсний түвшинд; б) орон нутгийн түвшинд; в) салбарын түвшин, зэрэг чиглэлээр НҮБ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн үр дүнтэй арга хэмжээний тоо	0	9	9
Яриа хэлэлцээ, шийдвэр гаргах, энхийг тогтоох үйл явцад НҮБ-ын дэмжлэгтэйгээр оролцсон, оролцож байгаа эмэгтэйчүүд, залуучуудын тоо	0	25918 залуучууд, 8349 эмэгтэйчүүд	37,310 залуучууд 2500 эмэгтэйчүүд
Эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоо, жендэрийн эрх тэгш байдлыг хангах үүднээс эмэгтэй удирдлагатай иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) болон бусад байгууллагууд, сүлжээдтэй байгуулсан түншлэлийн гэрээний тоо	0	14	22

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

**НҮБ-ын ТХХАХ** НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ

**ТХЗ** Тогтвортой хөгжлийн зорилтууд

**УИХ** Монгол Улсын Их Хурал

**ҮСХ** Үндэсний статистикийн хороо

**ҮТХН** Үндэсний тодорхойлсон хувь нэмэр

**ҮСДИ** Үндэсний сайн дурын илтгэл

**ХПВ/HPV** Хүний папиллома вирус

**ХДХВ, БЗДХ** Хүний дархлал хомсдолын вирус

**СХЗГ** Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар

**НЭЭ** Нянгийн эсрэг эсэргүүцэл

**НЭМҮТ** Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

**ОНТНББНХХ** Олон нийтэд түшиглэсэн нярай болон бага насны хүүхдийн хооллолт

**ГБХТХ** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

**НЦҮТ** нэг цэгийн үйлчилгээний төвүүд

**БНХАУ** Бүгд Найрамдах Хятад Ард Улс

**ТМБС** Техник, мэргэжлийн боловсрол, сургалт

**ҮЭС/NES** Монгол Улсын экспортын стратеги

**ГЗЗ/GI** Монгол Улсын газар зүйн заалт

**ХААСТ/GAP** Хөдөө аж ахуйн сайн туршлага

**ЦТКТБХ/SOP** НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн Талуудын 17 дугаар бага хурал

**ЭУЦС/ CRM** Эрсдэлийн удирдлагын цогц систем

**УАӨТБҮХХ/CRS** Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлын үнэлгээний хуудас

**ОБЕГ** Онцгой байдлын ерөнхий газар

**ЧИП** Дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн чип багц

**УАӨЭИ/СRI** Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн индекс

**ХЭҮК** Хүний эрхийн Үндэсний Комисс

**ТЕГ** Монгол Улсын Татварын Ерөнхий Газар

**ҮДСУ** Үр дүнд суурилсан удирдлага

**ҮШД/NTA** Үндэсний шилжүүлгийн данс

**ХТБ/DPG** Хөгжлийн түншүүдийн бүлэг

**НҮБХХЧ/UNC-TAD** НҮБ-ын Худалдаа, хөгжлийн чуулган

**ОУХТ/ITC** Олон улсын худалдааны төв

**НҮБАНДЭЭЗНК** НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комисс

**ДДГ/UNGC** НҮБ-ын Даян дэлхийн гэрээ

**МУИС** Монгол Улсын Их Сургууль

**МУБИС** Монгол Улсын Багшийн Их Сургууль

**ХТУБ/НСТ** Хүмүүнлэгийн тусламжийн Удирдлагын баг

**ИНЗХ** Иргэний нийгмийн зөвлөлдөх хороо

**ХАТ/JWP** Хамтарсан ажлын төлөвлөгөө

**ХШҮБ** Хяналт-шинжилгээ, үнэлгээний баг

**МХБ** Мэдээлэл харилцааны баг

**ЗУБ** Захиргааны удирдлагын баг

**БҮАС/ВОС** Бизнесийн үйл ажиллагааны стратеги

**ХУХ** Хамтарсан Удирдах Хороо

**ҮДБ/RGs** Үр дүнгийн бүлгүүд

**БХШБ/IAТ** Байгууллагууд хоорондын үнэлгээний баг

**ЖТБЭЧ** Жендэрийн тэгш байдал ба эмэгтэйчүүдийг чадавхижуулах

**СТБ/PRMG** НҮБ-ын Санхүүжилт, түншлэлийн баг



НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ  
БАЙГУУЛЛАГА  
МОНГОЛ УЛС



**МОНГОЛ ДАХЬ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА:**

Twitter(X.com):

[@unmongolia](#)

Facebook:

[@unMongolia](#)

Youtube:

[@unMongolia](#)